

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1. “Эдийн засаг дэд бүтцийн хөгжлийн бодлого” зорилтын хүрээнд:							
1.1.1	Баялаг бүтээгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн хүүгийн дэмжлэг олгоно.	-	Борлуулалтын орлого, ашиг алдагдал	0	Эхний хагас жилд: 8 Жилийн эцэст: 15	“Баялаг бүтээгчдэд хүүгийн хөнгөлөлт үзүүлэх” хөтөлбөрийн арилжааны банкуудаар дамжуулан 30.0 гаруй тэрбум төгрөгийн зээл олгогдох боломж бүрдсэн. “Баялаг бүтээгчдэд хүүгийн хөнгөлөлт үзүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 12 дүгээр сарын 01-ны байдлаар арилжааны 2 банкнаас 7 аж ахуйн нэгж, 14 иргэнд хүүгийн хөнгөлөлттэй 3,5 тэрбум төгрөгийн зээл олгосон. Орон нутгийн төсвөөс 700 сая төгрөгийн санхүүжилтийг банкуудад олгосон.	100
1.1.2	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн аж ахуй нэгжүүдэд дэмжлэг үзүүлж, ажлын байр нэмэгдүүлнэ.	1000.000.000	Дэмжлэг үзүүлсэн ААНэгжийн тоо	12	Эхний хагас жилд: 5 Жилийн эцэст: 13	Дэд хорооны хурлаар төслүүдийг хэлэлцэн, аймгийн Засаг даргын А/534 тоот захирамжаар 10 аж ахуйн нэгжийн 900.0 сая төгрөгийн санхүүжилт хүссэн төслүүдийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд уламжилж 875.5 төгрөгийн зээлийг олгосон. 20 гаруй аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч ЖДҮҮ- эрхлэгчээр бүртгэж, тодорхойлт олгосон.	100
1.1.3	Жимс, жимсгэнийн аж ахуйг дэмжиж, газар олгож өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлж, төсөл хөтөлбөрүүдэд хамруулна.	УТ, ОНТ	Гүйцэтгэлийн хувь	90%	Эхний хагас жилд: 70% Жилийн эцэст: 100%	2025 оны байдлаар Ховд аймагт нийт өссөн дүнгээр 708.9 га талбайд 100 гаруй иргэн, аж ахуйн нэгж жимс жимсгэнэ тариалж байна. Энэ онд жимс жимсгэний аж ахуйг хөгжүүлэх зорилгоор орон нутгийн төсөвт 200.0 сая төгрөгийн санхүүжилтийг суулган Булган сумын жимс жимсгэний суулгац үржүүлдэг 8 аж ахуйг дэмжин ажиллалаа. 2025 оны Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлэнд Булган сумын “Торгон нутаг баян алтай” ХХК-ний Алим боловсруулах үйлдвэр байгуулах төсөл шалгарч 100.0 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагаагаа өргөжүүлээд байна.	100
1.1.4	“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд	УТ,	Хоршоонд хамрагдсан	980	Эхний хагас	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд арилжааны банкаар дамжуулан 2024 онд 605 хоршооны 1836 малчинд 59,7	

	“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөр хэрэгжүүлж, малчдын орлогыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.	ОНТ	иргэдийн тоо		жилд: - Жилийн эцэст: 1050	тэрбум төгрөгийн зээл, 2025 онд 174 хоршооны 440 малчинд 15,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд тус аймгийн хоршоонд нэгдсэн 2262 малчин 73,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан.	100
1.1.5	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, худаг уст цэгийг шинээр барихад бодлогын дэмжлэг үзүүлнэ.	УТ, ОНТ	Шинээр баригдсан бэлчээрийн худгийн тоо	1860	Эхний хагас жилд: 15 Жилийн эцэст: 1890	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд арилжааны банкаар дамжуулан 2024-2025 онуудад 17 сумын 779 хоршооны 2262 малчид 75,5 тэрбум төгрөгийн зээл авсан бөгөөд 2024 онд 605 хоршооны 1836 малчинд 59,7 тэрбум төгрөгийн зээл, 2025 онд 174 хоршооны 440 малчинд 15,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан байна. Мөн энэ онд Буянт, Мянгад, Жаргалант, Эрдэнэбүрэн, Булган, Ховд, Алтай, Манхан, Дарви зэрэг сумууд хоршоог хөгжүүлэх сангаасаа 32 хоршоонд 815,6 сая төгрөгийн зээл олгосноор 37 ажлын байр нэмэгдэж, 45 ажлын байр хадгалагдсан байна.	100
1.1.6	Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлж, малын гений санг хамгаалж, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.	УТ, ОНТ	Гүйцэтгэлийн хувь	50%	Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст: 100%	Аймгийн хэмжээнд нийт 2714 уст цэг байгаагаас 465 инженерийн хийцтэй, 2243 энгийн уурхайн, 6 усан сан байна. 2025 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Буянт, Дарви, Мөнххайрхан сумдад 3 худгийг нийт 103.5 сая төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Манхан, Ховд сумдад 2 худгийг нийт 75.0 сая төгрөгөөр буюу нийт 5 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргаж, сум орон нутгийн өмчид хүлээлгэн өгөөд байна.	100
1.1.7	Газар тариалангийн үйлдвэрлэлийг механикжуулж, техник дундын үйлчилгээг бий болгоно.	УТ, ОНТ	Гүйцэтгэлийн хувь	50%	Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст: 100%	Энэ жил Алтай сумын Алтайн улаан үүлдрийн цөм сүргийн 3000 толгой ямаа, Манхан сумын 60 толгой үхэр, 600 толгой бог, Дөргөн суманд 830 толгой бог мал, Буянт суманд 300 толгой бог, 50 толгой үхэр, Чандмань суманд 100 толгой үхэр, 200 толгой бог мал, Мөст сум 720 толгой бог малд буюу нийт 210 үхэр, 5650 бог малд үзлэг ангилалтыг хувийн мал эмнэлэг, үржлийн нэгжүүдээр хийлгээд байна.	100
1.1.8	Малын гоц халдварт, халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандах, эрт илрүүлэх, тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, анхан шатны Мал эмнэлгийн байгууллагыг нэгдсэн бодлого, удирдлагаар хангана.	УТ, ОНТ	Гүйцэтгэлийн хувь	90%	Эхний хагас жилд: 70% Жилийн эцэст: 100%	2025 онд Ховд агро парк ХХК-н Техник дундын үйлчилгээний төвд хаврын тариалалтын үеэр нийт 41 иргэн, газар тариалан эрхлэгчдээс газар хагалуулах, модны нүх ухуулах захиалга ирснээс 13,93 га газар хагалж, 1656 ширхэг модны нүх ухах үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн намрын хадлангийн ажилд 90-100 морины хүчтэй трактор, хаман боогчийн хамт 3 ш, 34 морины хүчин чадалтай трактор хадуур, тармуурын хамт 3 ш, нийт 6 иж бүрдэл техник ажиллаж 56 иргэний 56580 ширхэг пресс өвсийг боох үйлчилгээ үзүүллээ.	100

1.2. "Хотын төлөвлөлт, шинэчлэл" зорилтын хүрээнд:

1.2.1	Шинэ суурьшлын бүсэд стандартын шаардлагад нийцсэн 1200 айлын орон сууцны хорооллыг байгуулна.	Улсын төсөв	Айл өрхийн тоо	4008	Эхний хагас жилд: 4150 Жилийн эцэст: 4308	Жилд дунджаар 200-250 айлын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Энэ жилийн хувьд 300 айлын орон сууцны ажлыг хүлээн авахаар ажиллаж байна. Ингэснээр Ховд хотод 4627 айлын орон сууцтай болно. Цаашид газар олголт, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар "Ховд орон сууцны корпораци" ОНӨХХК-ийг байгуулсан.	100
1.2.2	456 айлын түрээсийн орон сууцны барилгыг үргэлжлүүлэн барьж ашиглалтад оруулснаар агаар, хөрсний бохирдол буурч, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлнэ.	Улсын төсөв	Айл өрхийн тоо	120	Эхний хагас жилд: 150 Жилийн эцэст: 180	2025 онд түрээсийн орон сууц төсөл хэрэгжээгүй. Сайдын багцаас Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөрийн 1 дүгээр үе шатыг аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах улсын төсвийн хөрөнгийг бүсчлэн шийдвэрлэж, Ховд аймгийн Булган, Чандмань, Дарви, Зэрэг сумдад 8–15 айлын орон сууцны хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэгдсэн. Үүнээс Дарви-8 айл, Булган-15 айлын барилга угсралтын ажил эхэлсэн.	ХБ
1.2.3	Газрын харилцааны цахим шилжилтийн ажлыг эрчимжүүлнэ.	42.000 .000	Сумдын тоо	3	Эхний хагас жилд: 4 Жилийн эцэст: 5	Ховд аймгийн хэмжээнд салбарын үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор Жаргалант суманд 2, Үенч суманд 1 нийт 3 киоск ажиллаж, иргэдэд цахим үйлчилгээг үзүүлж байна	100
1.2.4	Нутаг дэвсгэрийн хэмжээнд байрлах гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах болон хаягийн тэмдэг, тэмдэглэгээний ашиглалт, хадгалалт, хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	60%	Эхний хагас жилд: 70% Жилийн эцэст: 80%	Аймгийн хэмжээнд шинээр хаягжуулах шаардлагатай Жаргалант сумын Буянт багт шинээр үүссэн 19 дүгээр гудамжны 138 нэгж талбарыг хаягжуулахаар судалгааг гаргасан. Сумын ИТХ-аар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна.	100
1.2.5	Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шалгалт хийж зөрчлийг	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	60	Эхний хагас жилд: 70 Жилийн	Аймгийн орон нутгийн төсвөөс 30 хувийг, Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох төслөөс 70 хувийн санхүүжилтийг шийдвэрлэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тендэрийг зарлаж, шалгаруулсан. Гүйцэтгэгч	100

	арилгана.				эцэст: 80	“Газар дэлхий” ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 24/152 тоот зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулж, гэрээний дагуу төлөвлөгөө тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 6 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлуулсан.	
1.2.6	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор бүх сумын нутаг дэвсгэрийн ерөнхий хөгжлийн төлөвлөгөө, зураг төслийг иргэдийн оролцоонд тулгуурлан боловсруулна.	Улсын төсөв	Сумдын тоо	6	Эхний хагас жилд: 8 Жилийн эцэст: 10	Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн тухайн сумдад үүрэг чиглэл өгч орон нутгийн төсөвтөө тусгуулах чиглэл өгсөн.	100
1.2.7	Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний шинэчлэн боловсруулна.	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	70%	Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст: 100%	Аймгийн орон нутгийн төсвөөс 30 хувийг, Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох төслөөс 70 хувийн санхүүжилтийг шийдвэрлэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тендэрийг зарлаж, шалгаруулсан. Гүйцэтгэгч “Газар дэлхий” ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 24/152 тоот зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулж, гэрээний дагуу төлөвлөгөө тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 6 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлуулсан.	100
1.2.8	Шаардлагатай байршлуудад хотын стандартад нийцсэн дахин болон хэсэгчилсэн төлөвлөлт хийнэ.	1500,0 сая	Гүйцэтгэлийн хувь	10%	Эхний хагас жилд: 50% Жилийн эцэст: 80%	Ховд хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу Жаргалант сумын 4 бүсийн 276,51 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Үүнд: Гэр хорооллын бүс-144,3 га, Холимог бүс-92,88 га, Амины орон сууцны бүс-31,44 Га, Худалдаа үйлчилгээний бүс-7,89 га тендер зарлагдаж гүйцэтгэгч шалгаран гэрээ хийнэ эхлэлийн тайлан буюу одоогийн байдлын судалгааны тайланг ирүүлсэн байна	50
1.2.9	Хотын дүрэм боловсруулж, нийт иргэдээр хэлэлцүүлэн баталж, хэрэгжүүлнэ.	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	0%	Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст:	Хотын дүрмийн төслийг мэргэжлийн байгууллага, судлаачдын оролцоотойгоор боловсруулхаар ажиллаж байна	10

					100%		
1.2.10	Барилгын гол нэр төрлийн материал үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	0%	Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст: 100%	Үйлдвэр технологийн паркийн 170 га газрын талбайд үйлдвэрлэл хөгжүүлэх ажлын эхлэл болгож вольфрам боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. Тус ажлыг гүйцэтгэгчид Барилгын тухай хууль болон холбогдох журмын дагуу үйл ажиллагаагаа явуулах зөвлөгөө, мэдээ мэдээллийг өгч, хамтран ажиллаж байна	100
1.2.11	Ногоон барилгын стандартыг хангасан амины тохилог орон сууц барих санаачилгыг дэмжинэ.	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	0%	Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст: 100%	Улсын төсвийн 12,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын цэвэр, бохир усны нийт 25446 м шугам сүлжээ хийгдсэн. Үүнээс цэвэр-13733м, бохир-11713м байна. Мөн гэр хорооллын салбар шугам сүлжээ болох орон нутгийн төсвийн 3,0 тэрбум төгрөг тусгагдсанаар энэ жилд 500,0 сая төгрөгөөр 1500 м шугам сүлжээний ажил хийгдсэн. Ингэснээр Ховд хотод 558 айл өрх цэвэр бохир усны шугам сүлжээнд бүрэн холбогдсон. Цаашид гэр хорооллын иргэд хашаандаа сайхан амьдрах боломж бүрдэнэ. Мөн цахилгааны шөнийн хөнгөлөлтөнд бүрэн хамрагдаж байна.	100
1.2.12	Гэр хорооллыг “Хаус хороолол” болгох иргэдийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	20%	Эхний хагас жилд: 50% Жилийн эцэст: 100%	Улсын төсвийн 12,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын цэвэр, бохир усны нийт 25446 м шугам сүлжээ хийгдсэн. Үүнээс цэвэр-13733м, бохир-11713м байна. Мөн гэр хорооллын салбар шугам сүлжээ болох орон нутгийн төсвийн 3,0 тэрбум төгрөг тусгагдсанаар энэ жилд 500,0 сая төгрөгөөр 1500 м шугам сүлжээний ажил хийгдсэн. Ингэснээр Ховд хотод 558 айл өрх цэвэр бохир усны шугам сүлжээнд бүрэн холбогдсон. Цаашид гэр хорооллын иргэд хашаандаа сайхан амьдрах боломж бүрдэнэ. Мөн цахилгааны шөнийн хөнгөлөлтөнд бүрэн хамрагдаж байна.	100
1.2.13	Нийтийн орон сууц, сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжтай ойролцоо шатахуун түгээх станц болон хийн түлшний түгээгүүр байрлуулахыг хориглоно.	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	0%	Эхний хагас жилд: 50% Жилийн эцэст: 100%	Одоогийн байдлаар нийтийн орон сууц, сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжтай ойролцоо шатахуун түгээх станц болон хийн түлшний түгээгүүр байгуулах төсөл, арга хэмжээ байхгүй бөгөөд холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж байн	100
1.2.14	Амины орон сууцны болон хуучин орон сууцны дулаан алдагдлыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ.	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	20%	Эхний хагас жилд: 50% Жилийн эцэст:	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Алтайн буйлаастын 30 айлын орон сууцны гадна пасад засвар-200,0 сая, Хангамжийн 27 айлын орон сууцны пасад засвар-98,0 сая, Ширбазар-48 айлын гадна пасад засвар-90,0 сая, Үйлдвэрчний эвлэлийн гадна пасад засвар-50,0 сая төгрөгийг тус тус зарцуулан улсын комисс хүлээн авсан. Мөн спортын ордны барилгын гадна засварыг ажлыг хүлээн	80

					100%	авсан.	
1.2.15	Нутгийн зам төслийн хүрээнд хэрэгжүүлэх Мөнххайрхан сум чиглэлийн 63.5 км , Дуут сумын замын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	УТ	Хэрэгжилтийн хувь	20%	Эхний хагас жилд: 30% Жилийн эцэст: 45%	Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 63.5 км /Ховд, Мөнххайрхан сум/-н ажил эхэлсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар авто замын зураг төсвийн ажлыг “Ихэр мөнх” ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Цаашид улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн.	20
1.2.16	Жаргалант сумын гол авто замын эгнээг 4 болгон өргөтгөсөнөөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, түгжрэлийг бууруулсан байна.	УТ	Замын урт	6	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 12.5	Төсөв санхүүгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан ажил хийгдээгүй.	0
1.2.17	Аймгийн авто замын ачааллыг тэнцвэржүүлэх, зорчих хөдөлгөөнийг сайжруулах зорилгоор авто зам, зогсоолыг нэмэгдүүлэх, эвдрэлтэй авто замыг нөхөж, засварлана.	ОНТ	Хэрэгжилтийн хувь	34%	Эхний хагас жилд: 50% Жилийн эцэст: 100%	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 4.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий Жаргалант сумын авто замын засвар, шинэчлэлтийн ажлыг 7 байршилд хэрэгжүүлэхээр гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажиллаж байна. Прогресс сургуулийн авто замаас Домбот чиглэлийн авто зам-400м, Захын доод талын урд уулзвараас Голомт банкны байр хүртэлх авто замын зогсоол-2284м2, Хуучин номингоос шинэ Номин хүртэл авто зам шинэчлэлтийн 0,9км замыг байнгын ашиглалтад хүлээн авлаа. Жаргалант өрхийн эмнэлгээс Бүсийн оношилгоо, эмчилгээний төв хүртэлх авто зам-210м, 3-р сургуулийн дээд хэсгийн хорооллын доторх авто зам-400м, Хүүхдийн номын өргөөнөөс БОЭТ-ийн зүүн талын авто замтай холбох-340м гүйцэтгэл 90 гаруй хувьтай үргэлжилж байна. Захын дээд тал буюу Захын урд уулзвараас Билгүүн төв хүртэлх авто зам /3 эгнээ/-415м, Нутгийн удирдлагын ордны авто зогсоол 4975м2 ажлуудыг ирэх онд бүрэн дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.	100
1.2.18	Нутгийн зам төслийн хүрээнд шинээр баригдсан хатуу хучилттай авто замын засвар арчлалтын ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.	ОНТ	Хэрэгжилтийн хувь	0%	Эхний хагас жилд: 20% Жилийн эцэст: 50%	“Авто замын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК-тай 165 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гэрээг байгуулан Жаргалант сумын авто замын эвдрэлийг засварлах, нөхөөс хийх ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авлаа. Мөн Буянт голын бага гүүр, их гүүрний хооронд ус зайлуулах хоолойн засварыг 92 сая төгрөгөөр гүйцэтгүүлэн хүлээн авлаа.	100

1.3. “ХОГНЫ ШИНЭ МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ НОГООН АЙМАГ БОЛОХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.3.1	Хогны менежментийг сайжруулах ажлын хүрээнд төлөвлөгдсөн төсөл арга хэмжээний ажлын даалгаврыг боловсруулан, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган тайлагнана.	2,5тэр бум	Гүйцэтгэлийн хувь	90%	Эхний хагас жилд: 95% Жилийн эцэст: 100%	Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор 1 ковш, 3 бункер татагч, 48 бункер, зам талбай цэвэрлэгч машин, хог зөөвөрлөх самосвол автомашин, мананжуулагч автомашины техникийн тодорхойлолтыг бүрэн боловсруулан худалдан авах ажиллагааг зарлуулан улсын комисс хүлээн авсан.	100
1.3.2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг орон нутагт хангана.	100сая	Тарьж ургуулсан модны тоо	313940	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 320000	Нийтийн хэрэгцээний ногоон байгууламжид 7588 ш, тусгай хэрэгцээнд 1623 ш, хязраарлагдмал хэрэгцээнд 16441 ш мод тарьж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүллээ. Хавар болон намрын улиралд 17 сумын 176 төрийн болон, аж ахуй нэгжийн 5768 иргэн 50749 ш модыг 5га талбайг хамруулан тарьсан. Тамтын ойжуулалтын чиглэлээр Булган сум 23 га, Дөргөн сум 20 га, Дарви сум 20 га, Жаргалант сум 50 га, нийт 113 га талбайд ойжуулалт хийгдлээ. Мөст сум 15 га, Дуут сумын 2 га талбайн татмын ойжуулалтын хийлээ.	100
1.3.3	Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын дэглэм мөрдүүлж, усны нөөцийн хомсдлоос сэргийлнэ.	30,6 сая	Гүйцэтгэлийн хувь	50%	Эхний хагас жилд: 70% Жилийн эцэст: 100%	Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг бүрэн зураглаж холбогдох мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд сонсох ажиллагааг бүрэн хийж дууссан. Бүсийн дэглэмийг мөрдүүлэхээр Үенч, Бодонч, Булган голын онцгой хамгаалалтын бүсэд 20 ш самбарыг байрлуулж, Манхан, Мөст, Дуут, Булган, Мөнххайрхан суманд 88,6 сая төгрөгөөр 11 булгийн эхийг орон нутаг, төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран хамгаалсан.	100
1.3.4	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээний даалгаврыг боловсруулан, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах, тайлагнана.	1,9 тэрбум	Гүйцэтгэлийн хувь	90%	Эхний хагас жилд: 95% Жилийн эцэст: 100%	Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 12 арга хэмжээнд 2,2 тэрбум төгрөг төсөвлөн холбогдох хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг 100 хувь хугацаанд нь зарлуулан гүйцэтгэлийг хангасан.	100
1.3.5	Нийтийн эзэмшлийн	2,5	Гүйцэтгэлийн хувь	50%	Эхний	-Нийтийн хэрэгцээний ногоон байгууламжид 7588 ш, тусгай	100

	ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	тэрбум	йн хувь		хагас жилд: 80% Жилийн эцэст: 100%	хэрэгцээнд 1623 ш, хязраарлагдмал хэрэгцээнд 16441 ш мод тарьж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүллээ. Хавар болон намрын улиралд 17 сумын 176 төрийн болон, аж ахуй нэгжийн 5768 иргэн 50749 ш модыг 5га талбайг хамруулан тарьсан. Нийтийн эзэмшлийн зам талбайн өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, тохижилтыг сайжруулах зорилгоор 14 байршилд зүлэг, 10 байршилд цэцэг, 2 байршилд гоёлын болон бусад төрлийн мод бут сөөг тариалан ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүллээ.	
1.3.6	Тусгай зориулалтын ангийн дуудлага худалдаа зохион байгуулна.	50сая	Гүйцэтгэлийн хувь	90%	Эхний хагас жилд: 95% Жилийн эцэст: 100%	Монголд Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 242 дугаар тогтоолоор “Тусгай зориулалтаар 2025 онд агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай” манай аймагт спорт болон олзворын зориулалтаар 9 угалз, 22 тэх, соёлын зориулалтаар 2 угалз агнах зөвшөөрөл олгосоны дагуу дуудлага худалдааг аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/421 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэг дуудлага худалдааг зохион байгуулж 23 иргэн, 26 аж ахуйн нэгж оролцож хамгийн өндөр үнээр угалз 241,440,000, хамгийн бага соёлын угалз 19,940,000 төгрөг, тэх хамгийн өндөр 26,260,000, хамгийн бага 12,660,000 төгрөгөөр зарагдсан аймгийн төсөвт 2,249,520,000 төгрөгийг төвлөрүүллээ. Соёлын угалз хамгийн өндөр нь 21,440,000, бага нь 19,940,000 төгрөгөөр зарагдсан. Мөн 1 угалз агнагдаагүй байна.	100
1.4. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИЖ, ХӨГЖИХ, СУРАЛЦАХ, АЯ ТУХТАЙ АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ, ЧИНЭЭЛЭГ, ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ, ЭРҮҮЛ ХҮНИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
1.4.1	Эрүүл мэндийн салбарт “+80”, “Чадварлаг эмч, мэргэжилтэн”, “Эрүүл, чийрэг хүүхэд” “Эх хүүхдэд ээлтэй тусламж үйлчилгээ” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1000.0	Хэрэгжилтийн хувь	85-аас дээш	Эхний хагас жилд: 87-аас дээш Жилийн эцэст: 90-ЭЭС ДЭЭШ	Эрүүл мэндийн салбарт “+80”, “Чадварлаг эмч, мэргэжилтэн”, “Эрүүл, чийрэг хүүхэд” “Эх хүүхдэд ээлтэй тусламж үйлчилгээ” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хэрэгжилтийн хувь 74,02 90-ээс дээш Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 5 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбарын “80+” төсөл арга хэмжээг 4 зорилт, 30 арга хэмжээний хүрээнд боловсруулан батлуулж 90 хувьтай хэрэгжсэн байна. Эрүүл амьдралын дадал хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэх зорилгоор “80+ Өглөөний алхалт” арга хэмжээ, “Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээнийг 2 үе шаттайгаар зохион байгуулсан ба эрэгтэйчүүдийн дунд зонхилон тохиолдох өвчин эмгэгийг илрүүлэх үзлэг, шинжилгээ буюу “Эрүүл эр хүн”, Сүрьеэ өвчнийг илрүүлэх үзлэг шинжилгээг сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж нийт 16 сумын 2804 хүн хамрагдаж эмчилгээ, үйлчилгээ авсан байна. Мөн 15 сумын ундны усны эх үүсвэрээс дээж цуглуулан 58 дээжийг шинжлүүлэхээр лаборатори руу явуулсан. “Чадварлаг эмч,	90

						<p>мэргэжилтнийг дэмжих, урамшуулах журам"-ын дагуу 21 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг 30 хүртэлх сая төгрөгөөр урамшуулж нийт 591.2 сая төгрөгөөр урамшуулан алдаршууллаа. 2 хамт олонг оны сүүлээр урамшуулахаар хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Булган нэгдсэн эмнэлэгт "Дутуу нярайн тасаг" тохижуулах шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахаар ОНХС 43.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Амьсгалын аппарат -1, тариурын шахуурга- 1, нярайн хяналтын монитор-1, ургийн СТГ-1 тоног төхөөрөмжөөр хангалаа. Мөн "Зуны сувилал" арга хэмжээнд 0-5 хүртэлх насны нийт 254 хүүхэд хамрагдсан. Хүүхдийн анагаахын чиглэлээр ажиллаж байгаа эмч нарт Хүүхдийн Өвчний Цогц Менежмент /ХӨЦМ/-ийн хүрээнд мэдлэг, мэдээллээр хангах, тэдний чадавхыг дээшлүүлэхэд нь мэргэжлийн дэмжлэг өгөх зорилготойгоор 50 эмчийг сургалтад хамрууллаа. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг MRI аппаратаар хангахаар улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тендер Эрүүл мэндийн яаманд зарлагдаж "Си Ай Ти" ХХК (3,745,000,000) шалгарсан.</p>	
1.4.2	Иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулж халдварт, халдварт бус өвчлөлийг бууруулна.	-	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн хамралтын хувь	54.0	Эхний хагас жилд: 55.0 Жилийн эцэст: 56.0	<p>Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ оношилгоонд 33620 хүүхэд хамрагдсан байна. Насанд хүрэгчид нийт 28372 хүнийг хамруулж аймгийн хэмжээнд урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 61992 хүнийг хамруулаад байгаа ба нийт хамрагдвал зохих хүн амын 68.8% хамрагдаад байна. Үзлэгт хамрагдсан үйлчлүүлэгчийн 13.9% нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг тэргүүлж байна. Тэргүүлэх өвчлөлд нойр булчирхайн өвчин 42,6%, архаг өнгөц гастрит 16,5%, элэгний өөхжилд 11,9%, бөөрний архаг үрэвсэл, чихрийн шижин 8%-ийг тус тус эзэлж байна. 2025 онд ходоодны хорт хавдар-37, хөхний хоргүй хавдар-27, бамбайн хоргүй хавдар-24, улаан хоолойн хоргүй хавдар-7, умайн хүзүүний хоргүй хавдар-9 илэрсэн байна. Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаал, Аймгийн Засаг даргын А/338 захирамжийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдад нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих насны 2131 хүүхдээс нүдний үзлэгт 1265 буюу 59,4%, шүдний үзлэгт 2032 буюу 95,4%, зүрхний үзлэгт 2013 буюу 94,5% хамрагдлаа. Зүрхний эмгэг илрүүлэх үзлэгт 2013 хүүхэд хамрагдсанаас зүрхний цахилгаан бичлэг өөрчлөлттэй 555 хүүхэд оношлогдсон. Мөн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Зүрх судас хэрэх, эрчимт эмчилгээ сэхээний тасгийн эрхлэгч Хүүхдийн зүрх судас, холбогч эдийн эмгэг судлаач эмч Б.Ундрал Ховд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ажиллаж нарийн</p>	100

						мэргэжлийн эмчийн үзлэг, зүрхний эхоны шинжилгээнд хамрагдвал зохих 555 хүүхдээс 428 хүүхдийг үзлэгт хамруулснаас Зүрхний төрөлхийн гажигтай 16 хүүхэд, Хэрэх өвчний шалтгаант хавхалгын эмгэгтэй 48 хүүхэд оношлогдож эмчийн хяналтад авч, зөвлөгөө өгсөн. Шүдний эмгэг илрүүлэх үзлэгт 2032 хүүхэд хамрагдсанаас 1647 хүүхэд шүдний эмгэгээр оношлогдсоноос 1107 хүүхдийг эмчилгээнд хамрууллаа. Нүдний эмгэг илрүүлэх үзлэгт 1265 хүүхэд хамрагдсанаас 120 хүүхэдэд нүдний эмгэг оношлогдсон байна.	
1.4.3	Бүсийн оношилгоо эмчилгээний төвд MRI аппарат, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	4000.0	Тоног төхөөрмжийн тоо	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг MRI аппаратаар хангахаар улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн яам тендер зарлаж “Си Ай Ти” ХХК (3,745,000,000) шалгарсан. 2025 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх зорилгоор СЭМТ, ӨЭМТөвүүдэд 21 ширхэг 73,8 сая төгрөгийн өртөг бүхий зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн андралогийн кабинетад 1 ширхэг мэс заслын ор 15,0 сая төгрөг, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 5,0 сая төгрөг, кварц 3 ширхэг 1,2 сая төгрөг хүчилтөрөгч өтгөрүүлэгч 1 ширхэг 3,2 сая нийт 9,2 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, 100 ширхэг 192,0 төгрөгийн өртөг бүхий компьютерыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан, өгч ажиллалаа. Булган нэгдсэн эмнэлэгт “Дутуу нярайн тасаг” тохижуулах нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг “Гэгээн хутагт” ХХК ОНХС 43.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар амьсгалын аппарат 1, тариурын шахуурга 1, нярайн хяналтын монитор 1, ургийн СТГ 1 тоног төхөөрөмжөөр хангалаа.	100
1.4.4	Цэцэг сумын эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барьж, Мөст, Зэрэг сумын эрүүл мэндийн төвийн барилгад өргөтгөл, засвар хийнэ.	2400.0 УТ 433.0 ОНХО	Гүйцэтгэлийн хувь	0	Эхний хагас жилд: 20% Жилийн эцэст: 50%	Улсын төсвийн 3450,0 хөрөнгө оруулалтаар Цэцэг сумын эрүүл мэндийн төвийн барилгыг “Турилахт” ХХК барьж дуусган 2025 оны 11 сарын 17-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн. Мөн Мөст сумын эрүүл мэндийн төвийг “Ганбүрэн” ХХК барьж 85% гүйцэтгэлтэй байна. Зэрэг сумын эрүүл мэндийн төвийн засварыг “Хан жист оргил” ХХК (ОНХС 429.8 сая) хийж гүйцэтгэн, эмнэлэг хэвийн ажиллаж, анхан шатны эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний орчин нөхцөл сайжирч, хүртээмж нэмэгдлээ.	90
1.4.5	Жаргалан ӨЭМТ-ийн барилгыг өргөтгөж, Баатархайрхан ӨЭМТ-ийг засварлаж, Бугат ӨЭМТ-ийг сургалтын	245.0 ОНХС ,ОНХ О	Гүйцэтгэлийн хувь	0	Эхний хагас жилд: 20% Жилийн	Жаргалан, Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилгын өргөтгөлийг “Жаргалан цагаан алт” ХХК (120.0 сая), “Өндөр Чан Гүн” ХХК (350.0 сая) гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийн орчин нөхцөл сайжирч, хүртээмж нэмэгдлээ. Бугат	100

	тоног төхөөрөмжөөр хангана.				эцэст: 50% -с дээш	ӨЭМТ-ийг сургалтын тоног төхөөрөмжийг “Ариун гантиг” ХХК (32.9 сая) нийлүүллээ.	
1.4.6	БОЭТ-ийн өргөтгөлийн барилгын гадна шугам сүлжээ, дэд бүтцийн ажлыг эхлүүлнэ.	900.0	Гүйцэтгэлийн хувь	0	Эхний хагас жилд: 20% Жилийн эцэст: 50-с дээш	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн өргөтгөлийн барилгын газрыг чөлөөлж, Азийн хөгжлийн банкны 6 төслийн хүрээнд зураг төслийн ажлын тендер нь зарлагдаж “Татах хүч” ХХК шалгаран ТЭЗҮ боловсруулж байна.	100
1.4.7	Уламжлалт, нөхөн сэргээх, шүд амны хөндийн тусламж үйлчилгээг өргөжүүлж хөгжүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 70%	2025 оны 1 дүгээр улиралд Булган, Мөнххайрхан сумууд ЭМЯ-аас, Даври, Зэрэг сумууд хандиваар, Мөст сум аймгийн хөрөнгө оруулалтаар, Дөргөн, Манхан, Мянгад, Цэцэг, Үенч, Буянт сумууд орон нутгийн санхүүжилтээр тус тус шүдний кабинетаар хангагдаж, Булган, Мөнххайрхан, Мянгад, Үенч, Буянт сумууд мэргэжлийн шүдний эмчийг үндсэн ажилтнаар авч, бусад сумууд хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүдийг гэрээгээр авч шүдний тусламж үйлчилгээг үзүүлж байна. Монголын Нэгдмэл Анагаах Ухааны Нийгэмлэгтэй хамтран “Баруун бүс нөлөөлөл-2025” хэлэлцүүлэгт Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Увс аймгийн уламжлалтын 32 эмч мэргэжилтнүүд хамрагдлаа. Мөн “Монголын уламжлалт анагаах ухааны хувь хүний өвөрмөц чанарыг хэрхэн тодорхойлох вэ, идээ ундаа, явдал мөрийн аргаар өвчнөөс сэргийлэх арга” сэдвээр сургалт зохион байгуулж 37 хүнийг хамруулан ажиллалаа. Тайлант мэдээгээр 21 төрлийн уламжлалт эмчилгээнд 18671 хүн, 14 төрлийн сэргээн засах эмчилгээнд 11753 хүнийг хамруулан ажилласан байна.	90
1.4.8	Эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг нэмэгдүүлнэ.	-	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хэрэгжилт /хувиар/	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: гүйцэтгэлээр	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03, 04 дүгээр тогтоолоор Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Булган сумын нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж байна. Төсвийн төлөвлөгөөгөөр Бүсийн оношилгоо эмчилгээний төв төлөвлөгөөгөөр 20,745,548,900 төгрөг, гүйцэтгэлээр 21,767,555,806 төгрөг, Булган сумын нэгдсэн эмнэлэг төлөвлөгөөгөөр 3,939,712,100 төгрөг, гүйцэтгэлээр 4,091,277,049 төгрөг, сумын эрүүл мэндийн төвүүдийн төлөвлөгөөгөөр 19,142,867,400 төгрөг, гүйцэтгэлээр 17,465,718,019 төгрөгийн санхүүжилт авсан байна.	100

1.5. БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД МАССЫН СУРГАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЖ БАГШИЙН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.5.1	Боловсролын салбарт хэрэгжих “Чадварлаг багш”, “Эх оронч-Монгол хүүхэд” төсөл арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.	2000.0	Төсөл арга хэмжээ	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 2	Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, багшийн мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих, массын сургалт, анги танхим дүүргэлт, сургалтын байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ өндөр ур чадвартай багш нарт дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Энэ онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Манхан, Мөнххайрхан сумын сургууль, Үенч суманд багийн сургуулийг шинээр барьж, Жаргалант сумын Бичигт багийн цэцэрлэг, 4-р цэцэрлэгийн өргөтгөл, Манхан сумын дотуур байрны барилгыг энэ оны 12 сард хүлээн авахаар төлөвлөж байна. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 4-н сургуулийн барилгыг 1 тэрбум 279,7 сая төгрөг, 8-н цэцэрлэгийн барилгыг 1 тэрбум 415,6 сая төгрөг, 4-н сургуулийн дотуур байрны барилгыг 706 сая төгрөг, нийт 3,4 тэрбум төгрөгөөр 16 барилгын иж бүрэн болон хэсэгчилсэн засвар хийж гүйцэтгэлээ. Боловсролын салбарын “Ховдын ирээдүй” төсөл арга хэмжээний урамшууллын журамд заасны дагуу ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн 5, бага ангийн 5, СӨБ-ын 3, их сургуулийн 1, мэргэжлийн боловсролын байгууллагын 1, нийт 15 багшийг тус бүр 30 сая төгрөг, нийт 450,0 сая төгрөгийн, байгууллага, мэргэжлийн хөгжлийн бүлэг, дотуур байр, сурагчийн өөрөө удирдах байгууллага, багш зэрэг 162 байгууллага, багш нарт 270,4 сая төгрөгийн, Бүсийн олимпиад, элсэлтийн шалгалтад амжилттай оролцсон 53 багш сурагчдын урамшуулал 52,7 сая төгрөгийн урамшуулал олголоо.	100
1.5.2	Сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бага, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	-	Хамран сургалтын хувь	СӨБ 89,0 Бага 97,8, Суурь 95,7	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: СӨБ 89,1, Бага 97,8, Суурь 95,7	Ерөнхий боловсролын 25 сургуульд 1916 багш, ажилчид ажиллаж, 760 бүлэгт 22920 суралцагч суралцаж, бага боловсролын хамран сургалт 97.4, суурь боловсролын хамран сургалт 96.2 хувьтай, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 964 багш, ажилчид ажиллаж, өдрийн бүлгээр 6664, хувилбарт сургалтаар 608 хүүхэд, нийт 7272 хүүхэд суралцаж, хамран сургалт 91,0 хувьтай байна.	100
1.5.3	Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулалтыг нэмэгдүүлнэ.	-	ХБХ-ийн хамралтын хувь	79,6	Эхний хагас жилд: - Жилийн	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссын дүгнэлттэй 315 хүүхдийн судалгаа гаргаж 28 хүүхдийг цэцэрлэгт, 65 хүүхдийг НТБТ, 143 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд, хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй	90

					эцэст: 80%	236 сурагч буюу 74.9 хувь нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлаар 8 хүүхдийн асуудал хэлэлцэж сургуулиудад зөвлөгөө өглөө. Нэгдүгээр ангид элсэн суралцах хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй 21 хүүхдийн судалгаа гаргаж эцэг эх, багш нарт мэдээлэл хүргэлээ. 24 сургуулийн дэмжлэгийн багийн ахлагч нарт сургалт хийж арга зүй туршлагаа солилцлоо. 3, 7 дугаар сургуулийн хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж буй ментор багш нар 1, 2, Цаст-Алтай, Прогресс сургуулийн 128 багш нарт "Хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүй" сэдэвт сургалт зохион байгуулж арга зүй туршлагаа түгээн дэлгэрүүллээ. Хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн үүрэг оролцоо сэдвээр Улаанбаатар хотод 16 сургуулийн удирдлага, багш нарт туршлагаа түгээн дэлгэрүүллээ. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэдтэй ажилладаг 28 багш, 7 эмч нарт сургалт хийлээ. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж хамтран ажиллалаа.	
1.5.4	Хүүхэд, залуучуудын боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх тэтгэлгийн тоог нэмэгдүүлж, гадаадын их, дээд сургуульд суралцах оюутны тоог нэмэгдүүлэх арга хэмжээг санаачилж хэрэгжүүлнэ.	ОНТ	Хамрагдсан оюутны тоо	79	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 80	2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/898 дугаар захирамжаар Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох журмыг шинэчлэн батлуулж холбогдох байгууллагад хүргүүлсэн бөгөөд 12 дугаар сард журмын болзол, шаардлагыг хангасан 40 оюутанд 80 сая төгрөгийн тэтгэлэгийг олгоно. Ерөнхийлөгчийн Илгээлт-2100, хөтөлбөрт Ховд аймгаас 2021 онд 15, 2022 онд 16, 2023 онд 10, 2024 онд 7 сурагч нийт 48 сурагч сонгогдон суралцаж байна. Энэ жилийн 14 оюутан хэлний бэлтгэлд суралцаж байна. "МО ЭНКО" ХХК нийгмийн хариуцлагын хүрээн энэ хичээлийн жил 18 оюутанд тус бүр 1,5 сая төгрөгийн тэтгэлэг олголоо Монгол улсын их сургуулийн баруун бүсийн сургуульд сурч байгаа оюутнуудад аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох журмыг шинэчлэн баталж, 12 дугаар сард багтаан олгохоор төлөвлөн ажиллаж байна.	90
1.5.5	ЭЕШ-ын бэлтгэлийн явцын сайжруулж өмнөх оноос ахиулна	-	Дундаж оноо	507	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 510	Хөдөөгийн Ерөнхий боловсролын 17 сургуулийн 12 дугаар ангийн сурагчдад элсэлтийн шалгалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор эрчимжүүлсэн сургалтыг 2025 оны 4, 6 дугаар саруудад Буянт, Манхан, Алтай Эрдэнэбүрэн, Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуулиудад бүсчлэн зохион байгууллаа. Нийт 900 цагийн хичээлийг 54 ментор багш чиглүүлж, 726 сурагч хамрагдаж, Эх хэлний шалгалтад Ховд аймаг урд жилийн дундажаас 8.5 хувиар ахиулсан үр дүн гаргалаа. 2025-2026 оны хичээлийн жилийн 12 дугаар ангийн эрчимжүүлсэн сургалтыг 12 дугаар сард зохион	100

						байгуулахаар төлөвлөж байна. Элсэлтийн шалгалтын дундаж 507,1 байгаа нь өмнөх оноос 4 оноогоор буурсан боловч аймгуудын дунд эзлэх байр 3 -аар урагшилсан.	
1.6. “ХУВИЙН ХЭВШИЛ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗАМААР ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨРТ ШИЛЖИХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
1.6.1	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын салбарт Монгол гэр бүл, Бэрх биш ээлтэй, өсвөр насны хүүхдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ	380.0 ОНХС	Хэрэгжилтийн хувь	85% -с дээш	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 90% -с дээш	Монгол гэр бүл, Бэрх биш ээлтэй, өсвөр насны хүүхдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн танхимыг “Дезерет” ОУБ-ийн 19.6 сая төгрөгийн дэмжлэгээр засварлаж, тоног төхөөрөмжийг шинэчиллээ. Орчин нөхцөлийг сайжруулсны үр дүнд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд 350, бүлгийн уулзалтад 560 иргэн хамрагдсан байна. Гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх 45 удаагийн сургалт, арга хэмжээнд 6445 гэр бүл хамрагдаж өмнөх онтой харьцуулахад сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан гэр бүлийн тоо 23,3 хувиар өссөн үзүүлэлтэй байна. E-family нэгдсэн платформыг тус онд нэвтрүүлэх эгүй ба сургалтуудыг танхим хэлбэрээр зохион байгууллаа. Тайлант онд гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх 45 удаагийн сургалт, арга хэмжээнд 6445 гэр бүл хамрагдаж, өмнөх онтой харьцуулахад сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан гэр бүлийн тоо 23,3 хувиар өссөн үзүүлэлтэй байна.зохион байгуулж нийт 45 удаагийн арга хэмжээнд 6445 гэр бүл хамрагдаж Өмнөх онтой харьцуулахад сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан гэр бүлийн тоо 23,3 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Бэрхбиш ээлтэй төсөл арга хэмжээни хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эрт илрүүлэгт 88 хүүхдийг нарийн мэргэжлийн үзлэг оношилгоонд хамруулж 19 хүүхдийг гадаад болон дотоодын нарийн мэргэжлийн эмчид үзүүлж шаардлагатай үйлчилгээг авах талаар зөвлөгөөг мэдээллийг авсан. Зуны чийрэгжилтэд тархины саажилттай байнгын асаргаатай, дархлаа сул, ханиад томуунд өртөмтгий 21 хүүхдийг сувилалд хамруулснаар эрүүл мэндийн байдал нь сайжирч, жин нэмэгдсэн эерэг үзүүлэлтүүд гарсан байна. Өсвөрийн кабинетаар 2025 оны 10 сарын байдлаар нийт 5963 өсвөр насны хүүхэддэд эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан үзүүлсэн байна. Өсвөрийн кабинетаар 2025 оны 10 сарын байдлаар нийт 5963 өсвөр насны хүүхэддэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	100
1.6.2	Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг	-	сайн дурын даатгалд даатгуулагч	2945 2236	Эхний хагас жилд: -	Малчин, туслах малчны сайн дурын даатгалд хамрагдсан нийт 2820 даатгуулагчаас шинээр 462 малчин хамрагдсан байна. Газрын даргын баталсан төлөвлөгөөний дагуу Нийгмийн	100

	дээшлүүлж, сайн дурын даатгалын хамрах хүрээг өргөтгөн малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.		ийн тоо Малчин даатгуулагч ийн тоо		Жилийн эцэст: 3150 2300	даатгалын багц хууль, дүрэм журмын талаар ажил олгогч болон иргэд, даатгуулагчдад 45 удаагийн сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулж, 4581 иргэд, даатгуулагчдад мэдээлэл хүргэн ажилласан. Нийгмийн даатгалын 33 үйлчилгээ байгаагаас 29 үйлчилгээ бүрэн цахимжиж 8578 иргэд, даатгуулагчдад цахимаар үйлчилгээг үзүүлсэн байна.	
1.6.3	Хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар жил бүр 800-аас дээш ажлын байр шинээр бий болгоно.	-	ШАБ-ын тоо	850	Эхний хагас жилд: 860 Жилийн эцэст: 880	2025 оны 11 дүгээр сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн eJob системд нийт 886 ажлын байр шинээр бий болсон байна. Эдгээр ажлын байрыг ангиллаар нь авч үзвэл байнгын ажлын байр 577 буюу 65.1%, Улирлын чанартай ажлын байр 246 буюу 27.7%, Түр ажлын байр 63 буюу 7.1% Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйл ажиллагааны хүрээнд нийт 343 шинэ ажлын байр шинээр бий болсон .	100
<b>1.7. “БАЙГАЛИЙН БОЛОН СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАН ХЭРЭГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:</b>							
1.7.1	Аялал жуулчлалын салбарын төсөл боловсруулан хэрэгжүүлнэ.	ОНТ	Хэрэгжилтийн хувь	0%	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 30%	Аймгийн аялал жуулчлалын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн байгуулж, төлөвлөгөөны төслийг боловсруулан ажиллаж байна.	50
1.7.2	Гурван Сэнхэрийн агуй, Ишгэн толгой, Сангийн хэрэм зэрэг Монгол улсын соёлын өвийн жагсаалтад багтсан дурсгалт газруудыг түшиглэсэн мэдээллийн төв байгуулна.	Орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 30%	Аялал жуулчлалын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвөөс 19.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн аялал жуулчлалын мэдээллийн төвийг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, мэдээллийн төвийн үйл ажиллагааг нээж ажилууллаа. Тус төвөөр дамжуулан аймгийн үзэсгэлэнт газруудын маршрут, амралтын газар, түр буудаллах цэгүүдийн мэдээлэл, ая тухтай зөв зохистой аялах талаар зөвлөгөө мэдээллийг гадаад, дотоодын 150 гаруй жуулчид, иргэдэд хүргэсэн байна. “Ховд аялал” нэртэй цахим сайтын үйл ажиллагааг тогтмолжуулж аялагчдыг мэдээллээр хангах боломжийг бүрдүүллээ. Үүний үр дүнд тайлант хугацаанд 5714 гадаад жуулчид, 39760 гаруй дотоодын жуулчид манай аймгийн нутгаар аялж, олон угсаатны өв соёл, байгалийн үзэсгэлэнтэй танилцсан байна.	100
1.7.3	Аялал жуулчлалын Баруун бүсийн чуулган	Орон нутгийн	Арга хэмжээний	1	Эхний хагас жилд: -	Аялал жуулчлалын үйлчилгээний чанар стандарт, хүний нөөцийг чадавхыг дээшлүүлэх, тулгамдсан асуудлаа хэлэлцэх, туршлага солилцон хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “АЯЛАЛ	100

	зохион байгуулна.	төсөв	тоо		Жилийн эцэст: 2	ЖУУЛЧЛАЛ-ХАМТЫН ХӨГЖИЛ” зөвлөгөөнийг зохион байгууллаа. Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуулын 110 хүний төлөөлөл оролцсон зөвлөгөөний хүрээнд Аялал жуулчлалын дэд бүтэц, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, аялал жуулчлалын маркетинг менежмент, салбарын хүний нөөц, байгальд ээлтэй тогтвортой аялал гэсэн 5 салбар хэлэлцүүлэг сургалтыг сумдын удирдлагууд болон аймгийн хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын оролцоотойгоор тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжрууллаа.	
1.7.4	Угсаатны бүлгүүдийн уламжлал, соёл, урлагийг хөрш орнууд болон дэлхий нийтэд сурталчлан таниулах аялал жуулчлалын олон улсын наадмыг Алтайн бүс нутгийн улсуудтай хамтран зохион байгуулна.	Орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	70%	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100%	БНХАУ-ын Шинжаан Уйгурын Өөртөө Засах орны Өрөмч хотод зохион байгуулагдаж буй “Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх” олон улсын үзэсгэлэн нь “Ice-Snow Silk Road” буюу “Мөс, цасны Торгоны зам” сэдвийн хүрээнд явагдаж, өвлийн аялал жуулчлалын салбарын шинэ технологи, бүтээгдэхүүнтэй танилцаж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр санал солилцлоо. Ховд аймгийн өвөрмөц тогтоц бүхий байгаль, ан амьтан, түүх, үндэстэн ястнуудын соёл, зан заншил, дэд бүтэц, аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг нэг дор багтаасан Англи, Монгол хадмал орчуулга, дуу хоолой нь тайлбар оруулсан видео хийсэн.	70
1.7.5	Худалдаа, үйлчилгээ бүхий иж бүрэн тохижуулсан “Жуулчны гудамж” шинээр бий болгож, гадаад, дотоодын аялал жуулчдад үйлчлэх ая тухтай орчин бүрдүүлнэ.	Орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	50%	Эхний хагас жилд: 70% Жилийн эцэст: 100%	19-р зуунд хамаарагдах соёлын түүхэн дурсгалт байгууламжийн туурь "Сангийн хэрэм"-ийг хамгаалах, соёл, аялал жуулчлалын орон зай болгон хөгжүүлэх зорилгоор "Сангийн хэрмийн хадгалалт хамгаалалт ба хөгжүүлэлт" сэдэвт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагын 40 гаруй хүн оролцлоо. Төв 4-н замаас "Сангийн хэрэм" хүртлэх гудамжийг жуулчны гудамж болгохоор төлөвлөн ажиллаж байна.	30
<b>1.8. ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:</b>							
1.8.1	Уламжлалт найрамдалт харилцаатай хөрш зэргэлдээ муж, хот, сумдын хамтын ажиллагааг өргөжүүлж, найрсаг хөршийн иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны хүрээнд нийгэм, эдийн засаг,	-	Хэрэгжилтийн хувь	100	Эхний хагас жилд: Хэрэгжилтийг ханган ажилла сан байна Жилийн	Аймгийн Засаг дарга М.Амарсанаа тэргүүтэй албаны төлөөлөл БНХАУ-ын Алтай аймагт ажлын айлчлал хийж, Булган-Такашикен боомтын нүүрс тээврийн шинэ гарцыг хилийн 126-127 дугаар тэмдэгтэд барих, боомтоор 8 доош хүний суудалтай авто машинаар зорчих зэрэг асуудлаар Алтай аймгийн удирдлагуудтай санал солилцож, хоёр аймгийн 2025 онд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд гарын үсэг зурав. БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Шэнь Миньжуань Ховд аймагт ажлын айлчлал хийж, Булган боомтын нүүрс тээврийн шинэ гарц барихад тулгамдаж буй асуудалтай газар дээр нь	100

	худалдаа, соёл, хүмүүнлэг, зэрэг бүх салбарт өргөн хүрээтэй хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлнэ.				эцэст: Хэрэгжилтийг ханган ажилласан байна	танилцаж, аймгийн бүтэн өнчин 60 хүүхдэд тус бүр 500 000 төгрөгийн “Элчин сайдын нэрэмжит” тэтгэлгийг гардуулав. БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймгийн ЕБС-ын 13-15 насны 15 сурагч сурагч солилцооны хөтөлбөрийн хүрээнд Ховд аймагт зуны амралтаараа ирж, харилцан холбоо тогтоон урлаг, спорт, сурлагийн туршлагаа хуваалцаж, хамтдаа хөгжих боломж бүрдлээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний төвийн сонсголын бууралтай 7 хүүхэд, эмч, мэргэжилтнүүдийн хамт БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймагт эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, хүүхэд бүрийн сонсголын бэрхшээлийн түвшинг тодорхойлж, бүх хүүхдүүдэд сонсголын аппаратыг тохируулан хандивлаж, зөвлөгөө өгөв. БНХАУ-ын Шиньжяны Үйлдвэрлэл, барилгажилтын 6-р хэлтсийн Үжячюй хотын Худалдаа аж үйлдвэрийн танхимын орлогч дарга Хан Шинтун тэргүүтэй албаны төлөөлөлт Ховд аймагт айлчилж, газар тариалан, уул уурхай, барилга, сэргээгдэх эрчим хүчний салбарт хамтран ажиллах боломжийн талаар санал солилцов. Аймгийн Засаг даргын орлогч М.Баяртаар ахлуулсан ажлын хэсэг БНХАУ-ын ШУӨЗО-ны Цонж Хуй аймагт ажлын айлчлал хийж, нийгэм, эдийн засгийн асуудлаар санал солилцож, орон нутгийн аж ахуй нэгжийн хамтран ажиллах боломжийн талаар танилцуулав.	
1.8.2	“Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд АНУ, Солонгос, Канад, Франц зэрэг хөгжиж буй орнуудын хамтын ажиллагаа хөгжүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	100	Эхний хагас жилд: 80 Жилийн эцэст: 100	Аймгийн Засаг дарга М.Амарсанаа УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн айлчлалын албан ёсны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтаж Бүгд найрамдах Казахстан улсад албан томилолтоор ажиллаж, “Ховд аймаг болон Бүгд Найрамдах Казахстан Улсын Дорнод Казахстан муж хооронд ах дүү харилцаа тогтоох тухай санамж бичиг”-т гарын үсэг зурж, найрамдалт харилцаа тогтоов. Япон улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд М.Игавахараг гэргийн хамт Ховд аймагт айлчилж, Япон улсын Засгийн газраас Ховд аймагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр хамтын ажиллагааны талаар санал солилцож, "Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж" төслөөр Дарви сумын Ерөнхий боловсролын сургуулийн Дотуур байрыг засварлах гэрээнд гарын үсэг зурав. Швейцарын Женев хотноо зохион байгуулсан Европын хөөмийн анхны наадамд Хөгжимт драмын театрын морин хуурч, хөөмийч МУСТА Ч.Баатарсүрэн урилгаар оролцож, шүүгчээр ажиллав. Ховд аймаг болон БНКУ-ын Дорнод Казахстан муж хоорондын ах дүү харилцаа тогтоох санамж бичгийн хүрээнд Дорнод Казахстан мужийн Өскемен хотод зохион байгуулсан “Алтай инвест-2025” форумд ороолцож, “Шинэ Ховд” ҮТП -ийн төслүүд болон аж ахуй нэгжүүдийн талаар танилцуулж, орон нутагтаа хийхээр төлөвлөж буй төслүүдийн талаар танилцуулав. Итали улсын Турин хотноо	100

						зохион байгуулсан спортын "ТУРИН-2025" тусгай олимпын өвлийн наадамд Ховд аймгийн тамирчин Т.Солонго Цасны гуталтай гүйлт 25м, 50м зайд алтан медаль, тусгай байр эзэллээ. Манай аймгийн төлөөлөл БНСУ-ын Сөүл хотноо 2025 оны 04 дүгээр сарын 04-10-ны өдрүүдэд "KUACE-2025" олон улсын бүжгийн тэмцээнд оролцов. Киргизстан улсын Кара Суу хотод "Кара суу" опен олон улсын тэмцээнд Казахстан, Тажикстан, Узбекистан Киргизстан, ОХУ, Монгол гэсэн 6 улсын 970 тамирчин өрсөлдсөнөөс манай тамирчид Алт-5, Мөнгө-4, Хүрэл-3 нийт 10 медаль хүртлээ. Мөн АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ричард Буанган, Чех улсын элчин сайд Прага хотын амьтны хүрээлэнгийн дарга нар Ховд аймагт ажиллалаа.	
1.8.3	Олон улсын байгууллага болон төсөл хөтөлбөрийн байгууллага, бүс нутгийн түвшинд хамтын ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	100	Эхний хагас жилд: 80 Жилийн эцэст: 100	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II,III төслийн санхүүжилтээр "Цаг уурын автомат станцаар хангах" ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "АЧСВС" ХХК-аас цаг уурын тоног төхөөрөмж, цаг уурын автомат станцыг хүлээлгэн өгч, суурилуулалт, ашиглалт, хамгаалалт, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулав. Норвегийн тусламжийн байгууллагаас Ховд аймагт "Иргэний нийгмийн хамтын ажиллагааг бэхжүүлэх" бэлтгэл төслийг 2025-2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөв. "ЖАЙКА" ОУБ-ын "Өвсний үндэс" хөтөлбөрийн төслийн баг Ховд аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвд ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах орчны нөхцөл бүрдүүлэх, хувийн туслах үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал болон цаашид хэрэгжүүлэх боломжийн талаар санал солилцов. Хаан банк, UNICEF Mongolia, Боловсролын яам хамтран алслагдсан сум, багийн хүүхдүүдийн эрүүл, аюулгүй орчинд сурч, хөгжих боломж олгох зорилгоор Ховд аймгийн Үенч сумын Хөх үзүүр багт "БАГА СУРГУУЛЬ"-ийг барьж, ашиглалтад хүлээлгэн өгөв. Азийн хөгжлийн банкны МОН48706-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн бүтээн байгуулалтын хүрээнд баригдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн нээлтийн үйл ажиллагаанд Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Гэр Бүл, Хөдөлмөр, Нийгэм хамгааллын яамны төлөөлөл оролцлоо.	100
1.8.4	Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоо, санаачилгыг дэмжиж,	-	хэрэгжилтийн хувь	100	Эхний хагас жилд: 80 Жилийн	Аймгийн Засаг дарга М.Амарсанаа БНХАУ-ын Шанхай хотноо зохион байгуулсан "Аж үйлдвэрийн паркийн сургалт, хэлэлцүүлэг-2025" арга хэмжээнд оролцож, баруун бүсэд баригдаж буй "Шинэ Ховд" ҮТП-ийн бүтээн байгуулалт, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн талаар танилцуулж, хамтран ажиллах, сайн туршлагаас орон	100

	бүс нутгийн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, хамтран ажиллана.				эцэст: 100	нутагтаа нэвтрүүлэх талаар санал солилцов. БНХАУ-ын Шиньжянь Үжячюй хотноо зохион байгуулсан “Чинху Олон улсын хөрөнгө оруулалтын форум”-д жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуй нэгжүүдийн хамт оролцож, “Ховд аймгийн Шим Ус ТӨААТҮГ, Шиньжяны Гуо Шин хөдөө аж ахуйн хөгжлийн корпораци”, “Шинэ Ховд Үйлдвэрлэл технологийн парк (Баруун бүс), Үжячюй “Эдийн засаг технологийн хөгжлийн бүс”, “Шинэ Асар ХХК, Шиньжяны Лу Фэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн хөгжлийн компани”, “Монгол улсын Лу Синь гадаадын хөрөнгө оруулалтын компани, Шиньжяны Хэн Жие импорт экспортын худалдааны компани”, “Пөн Хуй” олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын компани, Шиньжяны “Күнлун” гангийн компани” зэрэг аж ахуй нэгжүүд хооронд хамтран ажиллах гэрээ байгуулав. Бүгд Найрамдах Казахстан Улсын Дорнод Казахстан мужийн Өскемен хотод зохион байгуулсан “Алтай инвест-2025” форумд оролцож, “Шинэ Ховд” ҮТП болон аж ахуй нэгжүүдийн талаар танилцуулж, орон нутагтаа хийхээр төлөвлөж буй төслүүдийн талаар танилцуулав.	
--	--	--	--	--	------------	---	--

**1.9. ОЛОН УГСААТНЫ СОЁЛЫН ӨВИЙГ ХАДГАЛАН ХАМГААЛАН ӨВЛҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЖ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:**

1.9.1	Олон угсаатны соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлэх “Олон угсаатны өв, соёл урлаг” төсөл, “Түүх соёлын дурсгалыг гэрээгээр хамгаалагчдад урамшуулал олгох” , “Соёлын биет болон биет бус өвийг өвлүүлэн уламжлах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан иргэд, өвлөн уламжлагчдыг урамшуулах журам”-уудыг шинэчилж, хэрэгжүүлнэ.	600.0	Хэрэгжилт йн хувь	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 30	Аймгийн ИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 03 тоот тогтоолоор “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалуулах журам”, “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдад шагнал олгох журам-ыг тус тус батлуулсан.Улсын хамгаалалтад байгаа түүхэн дурсгалуудыг хамгааллуулах гэрээ байгуулан 13 суманд байрлах 22 дурсгалт газрыг 15 гэрээт хамгаалагчдад 23,6 сая төгрөгийн урамшуулал өгч хамтран ажиллаж байна.Төсөл арга хэмжээний хүрээнд соёлын биет бус өвийн 10 өвлөн уламжлагчийг тус бүр 500 мянган төгрөгөөр шагнаж урамшууллаа.	100
1.9.2	Морин хуур, икэл, лимбэ, тууль, цуур,	50.0	Арга хэмжээний	32	Эхний хагас	Соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд уран нугаралт, урианхай бий биелгээ, монгол бүжиг, цуур хөгжим, бөх, морь	100

	хөөмий, ардын богино болон уртын дуу, бий биелгээ, уран нугаралт, ардын уламжлалт тоглоом наадгай, аман аялгуу /ерөөл, магтаал/-ын шавь сургалтуудыг тогтмол зохион байгуулна.		тоо		жилд: - Жилийн эцэст: 38	цоллооч шавь бэлтгэх сургалтыг Монголын уран нугаралтын холбоо, Хөгжимт драмын театрын бүжигчид, өвлөн уламжлагч нартай хамтран зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд уран нугаралт, урианхай бий биелгээ, монгол бүжиг, цуур хөгжим, морь, бөх цоллоочийн шавь сургалтад 418 сурагчийг хамруулж, соёлын өвийг өвлөн уламжлууллаа. Соёлын биет бус өв"-ийн төв байгуулахаар судалж байна.	
1.9.3	Олон угсаатны соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлэхэд шаардлагатай судалгаа хийж цахим сан, архив бий болгоно.	ОНТ	Хэрэгжилтийн хувь	30	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 70	Олон угсаатны соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр тайлант онд 4 төрлийн цахим архивын санг бүрдүүлж ажиллалаа. Үүнд: Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийг алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлах зорилготой "НҮҮДЭЛЧИН" Дэлхийн соёлын фестивалийн Ховд аймгийн I-р шатны шалгаруулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж 158 өвлөн уламжлагчийн зураг, бичлэгийг архивлав. Монгол хөөмийн уламжлалт урын санг сурвалжлан илрүүлэх, судлан сурталчлах, өвлүүлэн хөгжүүлэх, хадгалан хамгаалах, билиг авьяастнуудыг тодруулж, алдаршуулах, хөөмийчдийн ур чадварыг нэмэгдүүлэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Олон улсын Хөөмийн VI наадмыг Ховд аймагт зохион байгуулсан бөгөөд энэхүү уралдаанд оролцсон 97 уран бүтээлчийн зураг бичлэгээр архивын сан үүсгэлээ.Мөн Торгууд угсаатны уртын дууг язгуур шинжийг хадгалан хамгаалах, сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлагчдын чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Торгууд" угсаатны уртын дууны сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, арга хэмжээнд оролцсон 45 өвлөн уламжлагчдын 20 гаруй зураг, бичлэгийг архивлалаа. "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам" –ын дагуу Ховд аймгийн Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого зохион байгуулагдаж байна.Энэхүү тооллогоор Музейн сан хөмрөгийн 935 дэсийн 3035 ширхэг үзмэрийг тоолж, улсын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулж, баримтжуулсан.	100
1.9.4	"Нүүдэлчин Монгол" олон улсын фестивальд оролцоно.	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо	3	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 4	Монгол Улсын соёлын биет бус өвийн олон төрөл зүйл, угсаатны бүлгийн онцлогийг таниулан сурталчлах, сэргээн хөгжүүлэх зорилго бүхий "Нүүдэлчин-2025 " соёлын фестивальд 60 гаруй өвлөн уламжлагчийн бүрэлдэхүүнтэй оролцож дэд байр эзэлж , олон угсаатны язгуур тоглолтоо отог болон төв тайзан дээрээс үзэгч олонд толилуулж язгуур урлагийг суртачлан таниуллаа. Уг фестивальд оролцсон оролцогчдод шагналын мөнгө болох 70.0	100

						сая төгрөгнөөс 600.000-2.500.000 төгрөгийн урамшууллыг олгосон.	
1.9.5	Хөөмийн сар арга хэмжээ /олон улсын Хөөмийн VIII наадмыг/ зохион байгуулна	ОНТ	Хэрэгжилтийн хувь	100	Эхний хагас жилд: 70 Жилийн эцэст: 100	Монгол Хөөмийн уламжлалт урын санг сурвалжлан илрүүлэх, судлан сурталчлах, өвлүүлэн хөгжүүлэх, хадгалан хамгаалах, билэг авьяастныг тодруулж алдаршуулах, хөөмийчдийн ур чадварыг нэмэгдүүлж олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ-тай хамтран 2025 оны 08 сарын 02-04-ний өдрүүдэд "Олон улсын хөөмийн VI наадам"-ыг зохион байгууллаа. Тус хөөмийн наадам-уралдаанд гадаадын 40-өөд манай улсаас 30-аад буюу 70-гаруй оролцогч 4 төрөлд авьяас, чадвараараа өрсөлдлөө. Гоцлол төрөлд-32 Хамтлаг төрөлд-6 Хүүхдийн гоцлол төрөлд-13 Орчин үеийн үзүүлбэрийн төрөлд-18 оролцсон. Уг наадмын хүрээнд "Монгол хөөмийн урлаг" эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан бөгөөд бага хуралд манай улсаас гадна ОХУ, Тува, БНХАУ-ын ШУӨЗорон, Өвөр монголын ӨЗО -ы 10 гаруй эрдэмтэн, судлаачид оролцож илтгэлээ танилцууллаа. Уралдааны шилдгүүд болон онцлох төрлүүдээс бүрдсэн "ГАЛА ТОГЛОЛТ"-ыг Ховд аймгийн ард иргэдэд толилуулсан арга хэмжээ болж өндөрлөв.	100
1.9.6	"Соёлын бүтээлч сар" аяныг зохион байгуулна.	ОНТ	Хэрэгжилтийн хувь	100	Эхний хагас жилд: 70 Жилийн эцэст: 100	Соёлын бүтээлч сар аяны хүрээнд Төрийн албан хаагчдын соёлын боловсрол, гоо зүйн үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн хариуцлага иргэний ухамсарыг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрлийн "МОНГОЛ БАХАРХАЛ" арга хэмжээг 5 төрлөөр 11 дүгээр сард зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 16 сум, 8 байгууллагын 190 гаруй төрийн албан хаагч оролцож соёлын боловсролоо дээшлүүллээ.	100
1.9.7	Кино театрын барилгыг ашиглалтанд оруулна.	1,000.10	Хэрэгжилтийн хувь	50	Эхний хагас жилд: 60 Жилийн эцэст: 100	Барилгын ажлын явц 90%, гадна тохижилтын ажлын явц 80% дотор тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдэж байна. Аймаг орон нутгаас дулааны шугам сүлжээг бүрэн шийдэх хэрэгтэй байна,.	90
1.9.8	Олон угсаатны театрын барилгын 2025 оны гүйцэтгэлд хяналт тавьж, дотоо заслын зураг төсөв гаргана.	4,488.00	Хэрэгжилтийн хувь	50	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 80	Шинээр баригдаж буй Олон угсаатны театрын барилгын гүйцэтгэлд 70%тай үргэлжиж байна. 2025 оны 09 сарын 12-18-ны хооронд Өмнөговь аймгийн Театртай танилцахаар Уран сайхны удирдагч С.Хадхүү, маркетингийн менежер М.Баатар, Зураач М.Ганочир нар Ховд аймгийн Хөгжимт Драммын Театрын шинэ барилгын гүйцэтгэгч компанитай хамтран туршлага судлахаар ажилллаж, шаардлагатай объектуудыг өөрчлүүлхээр саналаа хүргүүлж ажиллалаа. Үүнд Зрителийн том заалны тааз болон	70

						дотор хананы өнгө хүнд бараан өнгөтэй байсныг гэгээлэг өнгөөр солилуулах Хөгжмийн яамны өргөнийг нэмэгдүүлэх Жижиг заалны таазыг хүлээх заалны тааз шиг болгох Сандалын байршилд өөрчлөлт оруулах Том тайзны ключ педук штанкатдаа байрласан 3 өнгийн байх зэрэг жижиг хэсгүүдийг өөрчлөлт оруулахаар барилгын гүйцэтгэгч компанид санал хүргүүлж ажилласан байна.	
1.9.9	Ховд ВОХ цогцолбор Хүүхэд, залуучуудын контейнер номын санг барьж, шугам сүлжээнд холбоно.	973.0	Хэрэгжилтийн хувь	30	Эхний хагас жилд: 50 Жилийн эцэст: 100	Зураг төсөл нь магадгалаар орж баталгаажсан. Төсөв нь магадалд орхоор бэлтгэл хангасан байна. Гүйцэтгэлийн явцад техникийн нөхцөл нь гараагүйтай холбогдуулан ажил удааширч байна. Одоогоор барилга угсралтын ажил 20 хувьтай. Тус ажил нь магадлал хийгдэгдэж байгаатай холбоотой түр зогссон байна.	30
<b>1.10. “ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ЗАМААР ХӨГЖИЛ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:</b>							
1.10.1	17 сумын “Залуучуудын Хөгжлийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлж, залуучуудын Төрийн болон Төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулна.	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо	4	Эхний хагас жилд: 5 Жилийн эцэст: 7	Аймгийн засаг даргын 2025 оны 03 сарын 25-ны өдрийн дугаар А/183 тоот захирамжаар аймаг сумдын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, Залуучуудын хөгжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, аймгийн залуучуудыг дэмжих төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Бүх сумдуудад зөвлөлөө 100 хувь байгуулан ажиллаж байна.	100
1.10.2	“Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяныг зохион байгуулна.	ОНТ	Хамрагдагсдын тоо	806	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1306	Ховд аймгийн Боловсролын газар, Японы Хүүхдийг ивээх сан хамтран “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” Entrepreneurship focused Socio-Emotional Learning (ESEL) хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх 3 өдрийн онлайн танхим хосолсон сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалтаар багшаа бэлтгэснээр аймгийн 25 сургууль, Насан туршийн суралцахуйн төв, нэгжүүдэд ESEL сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж бүрдлээ.Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн санаачилгаар Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Боловсролын ерөнхий газар, Хадгаламжийн даатгалын корпораци хамтран ахлах ангийн сурагчдад санхүүгийн боловсрол олгох “Level-UP” хөтөлбөрийг хэрэгжүүлж Ховд аймагт нийт 15 багш, 418 суралцагч хамрагдаж, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээгээр 6 багш, 2 сургууль шилдгээр шалгарч, аймгийн дүнгээр “МАНЛАЙЛАГЧ АЙМАГ” цомын эзэн боллоо. Зуны сургалт 15, Элсэлтийн шалгалтад бэлтгэх сургалтыг бүсчлэн 2 удаа 726	90

						сурагч, IELTS өндөр оноо авах сургалтад 10, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зэрэг 10 гаруй арга хэмжээг зохион байгууллаа.	
1.10.3	“Залуучуудын оролцоо” орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн төсөл боловсруулан хэрэгжүүлнэ.	ОНТ	Хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: 10 Жилийн эцэст: 30	Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн шинэчилсэн найруулгад санал авах зорилгоор “Залуучуудын оролцоо” олон талт хэлэлцүүлгийг орон нутагт үе шаттайгаар зохион байгууллаа. Давхардсан тоогоор нийт 50 саналыг, залуучуудын оролцоо манлайлал, залуучуудын хөгжил, орчин нөхцөл гэсэн хоёр бүлэгт багцлан саналыг нэгтгэн Улаанбаатар хотноо болсон Залуучуудын оролцоо нэгдсэн чуулганд хүргүүлэв. Өсвөр үеийн залуучуудын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихээр Ховд аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нартай “Өсвөр насны хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд” анхан шатны хэлэлцүүлгийг зохион байгуулж, сэтгэцийн эрүүл мэндийн суурь судалгааны асуумж боловсруулан салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулж ажиллалаа. Монгол Улсад гэрэл зургийн алба үүсэн хөгжсөний 90 жилийн ойн хүрээнд гэрэл зурагчид, уран бүтээлчдийг дэмжин бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, залуу гэрэл зурагчдыг дэмжих зорилгоор “Photo week-2025” арга хэмжээг Ховд аймагт амжилттай зохион байгууллаа. Гэрэл зурагчдын нэгдсэн үзэсгэлэнд 16 гэрэл зурагчдын 123 бүтээлээс залуу гэрэл зураг сонирхогчдын 11 бүтээл оролцож, залуу гэрэл зурагчин Э.Буянзаяагийн “Хайрын мадригал”, “Сүргийн манлай” гэсэн 2 бүтээл бүсийн уралдаанд шалгарлаа. “Khovd Photo week-2025” арга хэмжээг нийт 2930 иргэн үзэж сонирхсоноос гадаадын 18 иргэн байна.	90
1.10.4	“Асуудал, шийдэл” Залуучуудын нэгдсэн чуулган зохион байгуулна.	ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1	Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн шинэчилсэн найруулгад санал авах зорилгоор “Залуучуудын оролцоо” олон талт хэлэлцүүлгийг орон нутагт үе шаттайгаар зохион байгууллаа. Давхардсан тоогоор нийт 50 саналыг, залуучуудын оролцоо манлайлал, залуучуудын хөгжил, орчин нөхцөл гэсэн хоёр бүлэгт багцлан саналыг нэгтгэн Улаанбаатар хотноо болсон Залуучуудын оролцоо нэгдсэн чуулганд хүргүүлэв.	90
<b>ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>							
<b>2.1. “ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭЧЛЭЛ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:</b>							
2.1.1	Аймгийн Засаг даргатай уулзах иргэдийг бүртгэж, Засаг дарга болон холбогдох албан тушаалтнуудтай	-	Өргөдөл, гомдлын тоо Шийдвэрлэлийн хувь	250 92%	Эхний хагас жилд: - Жилийн эцэст:	Аймгийн Засаг дарга долоо хоног бүрийн Пүрэв гарагийг иргэдтэй уулзах өдөр болгосон. Хуваарийн дагуу долоо хоног бүрийн пүрэв гараг болон шаардлагатай үед бусад өдрүүдэд Засаг даргатай уулзахаар ирсэн иргэд, байгууллагын төлөөллүүдийг хүлээн авч уулзан аймаг орон нутгийн эдийн засаг, нийгэм, эрүүл мэнд,	100

	уулзуулж, санал хүсэлтийг тэмдэглэн авч, шийдвэрлүүлнэ.				300 95%	боловсрол, соёл урлаг, спорт болон бусад асуудлаар санаа бодлыг нь сонсож, хариулт өгөн ажиллаж байна. Байгууллага, иргэдээс тавьж буй асуултад хариулт өгөх, шийдвэрлэх шаардлагатай санал хүсэлтийг холбогдох албан тушаалтан болон байгууллагад шилжүүлэн шуурхай шийдвэрлэж ажиллахыг үүрэг болгон биелэлтийг тооцон ажиллаж байна.		
2.1.2	Иргэдээс аймгийн Засаг дарга болон түүний Тамгын газарт ирүүлсэн, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлнэ.	-	Өргөдөл, гомдлын тоо - Шийдвэрлэлийн хувь	450	95%	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 500 98%	Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт ирсэн санал хүсэлт, өргөдөл гомдлын мэдээг 2024 оны 11 дүгээр сарын байдлаар нэгтгэн гаргахад нийт 436 өргөдөл, гомдол хүлээн авч, 308 өргөдлийг шийдвэрлэн хариу өгч, 68 өргөдлийг холбогдох байгууллага албан тушаалтанд уламжилж, 23 өргөдлийг шийдвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 91.5 хувьтай байна. Тайлант хугацаанд аймгийн Засаг дарга давхардсан тоогоор 360 гаруй иргэнийг биечлэн хүлээн авч уулзан асуудлыг шуурхай шийдвэрлэж, хариу өгч ажиллалаа.	100
2.1.3	Сум, байгууллагуудаас өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаарх улирлын мэдээ, жилийн эцсийн тайланг ЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хугацаанд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	-	Мэдээ, тайлангийн тоо - Тайлан, мэдээ ирүүлсэн сум, байгууллагын тоо Шийдвэрлэлийн хувь	3%	95.1%	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 3 98%	Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 06 дугаар хуралдаанаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2025 оны 1 дүгээр улирлын тайлан, 2025 оны 07 дугаар сарын 23-ний өдрийн 11 дүгээр хуралдаанаар 2 дугаар улирлын тайлан, 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 12 дугаар хуралдаанаар 3 дугаар улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг тус тус хэлэлцүүлэн дэмжүүлж, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хугацаанд нь тайлагнан ажиллав. Харин 4 дүгээр улирлын тайланг сум, байгууллагуудаас хүлээн авч нэгтгэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэхээр сум, байгууллагуудад албан тоот хүргүүлэн ажиллаж байна.	100
2.1.4	Засаг даргын цагийн менежментийг зөв төлөвлөн, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангаж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	100%		Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст: 100%	Засаг даргын цагын менежмент долоон хоног бүр төлөвлөн урьдчилан уулзалт, хурал цуглаан, цахим уулзалт, гадаад дотоодын зочид төлөөлөгчтэй хийх уулзалтын цагыг урьдчилан авч танилцуулж, төлөвлөгөөнд оруулж шаардлагатай мэдээллийг авч бэлтгэн ажиллаж байна.	100
2.1.5	Засаг даргаас албан тушаалтанд өгсөн үүрэг даалгаврыг албажуулж, хэрэгжилтэд хяналт	-	Хэрэгжилтийн хувь	100%		Эхний хагас жилд: 80%	Засаг даргаас байгууллага агентлагийн дарга, болон албан тушаалтанд өгсөн үүрэг даалгаврыг албан бичиг болон захирамжлалаар албажуулж үүрэг чиглэл өгч өгсөн үүрэг даалгаварын биелэлтийн талаарх хариу мэдээллийг хугацаанд нь	100

	тавьж ажиллана.				Жилийн эцэст: 100%	авч харъяа хэлтэс албаруу шилжүүлж ажилладаг.	
2.1.6	Сум, баг, байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох, аймгийн Засаг дарга түүний Тамгын газрын үйл ажиллагааг сум, баг, байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөх, зөвлөгөө, дэмжлэг мэдээллээр хангана.	-	-Зөвлөгөө, дэмжлэг, мэдээллээр хангасан сум, байгууллагын тоо	17 25	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 17 25	Сум, байгууллагуудтай холбогдолтой захирамж, албан бичгийг төлөвлөж холбогдох байгууллагад нь хүргүүлж хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн аймгийн удирдлагуудаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу "Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн", "Удирдах албан тушаалтны ажлын тайлангийн нээлттэй сонсгол", "Аймгийн дунд хугацааны стратеги /2025-2040/" хэлэлцүүлэг, хурал, сургалт, семинарын ажлыг зохион байгуулан холбогдох албан тушаалтнуудыг хамруулах ажлыг зохион байгуулж, ЗДТГ, сум, байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зөвлөгөө мэдээллээр ханган ажиллаж байна.	100
2.1.7	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг орон нутгийн телевиз, сонин хэвлэлээр сурталчилна.	-	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байгууллагын тоо	17 сум 22 байгууллага	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 17 сум 23 байгууллага	"Ховд аймгийн Засаг Даргын Тамгын Газар" фэйсбүүк пэйж нь 27 гаруй мянган дагагчтай. 2025 оны 12-р сарын 08-ны өдрийн байдлаар тус пэйжд 442 фото мэдээ, 240 видео мэдээ, рийл нийтэлжээ. Мөн ЗДТГ-ын хэлтсүүдээс ирүүлсэн зар, бусад холбогдох мэдээллийг цаг тухай бүрд нь нийтэлж иргэдэд мэдээллийг шуурхай хүргэн ажиллаж байна. Сард давхардсан тоогоор 100 мянган хэрэглэгч пэйжд хандаж, аймаг орон нутгийн мэдээллийг тогтмол авч байна. Албан ёсны вебсайтууд дахь мэдээллийн байршуулалт: <a href="https://khovd.gov.mn/">https://khovd.gov.mn/</a> сайт Сайтад 2025 оны 04-р сарын 28-ны өдрөөс эхлэн мэдээ мэдээллийг тогтмол байршуулж эхэлсэн. 2025 оны 12-р сарын 08-ны байдлаар нийт 201 фото мэдээ байршуулсан. 2. <a href="https://www.gov.mn/mn/organization/khovd-zdtg">https://www.gov.mn/mn/organization/khovd-zdtg</a> сайт Энэ онд нийт 350 фото мэдээ байршуулсан.	100
2.1.8	Аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн зохион байгуулна.	-	Зохион байгуулсан шуурхай зөвлөгөөний тоо	4	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 12	Тайлант хугацаанд аймгийн "Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн"-ийг 7 удаа зохион байгуулж, аймгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хяналт шинжилгээ үнэлгээний khovd.igovernment.mn цахим системд бүртгэж, биелэлт үр дүнг тооцож хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллаа. Мөн "Удирдах албан тушаалтнуудын ажлын тайлангийн нээлттэй сонсгол"-ыг 2025 оны 11 дүгээр сард Нутгийн удирдлагын ордны хуралдааны их танхимд зохион байгууллаа. Сонсголыг нийгмийн салбар, хууль эрхзүй болон санхүүгийн, байгаль орчин хөдөө аж ахуй, дэд бүтэц харилцаа холбооны чиглэлийн байгууллагууд гэж дөрвөн салбар болгон зохион байгуулсан бөгөөд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн 57 байгууллагын	100

						хийж хэрэгжүүлсэн ажил, хэрэгжилтийн явц, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэв. “Удирдах албан тушаалтнуудын ажлын тайлангийн нээлттэй сонсгол”-д аймгийн Засаг дарга М.Амарсанаа, Засаг даргын орлогч Л.Энхбаяр, ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Баасанхүү, хэлтсийн дарга нар, салбар хариуцсан мэргэжилтнүүд оролцож, байгууллагын ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуулт асууж, санал солилцлоо.	
2.1.9	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу архивын өрөө тасалгааг стандартын дагуу тохижуулна.	-	Хэрэгжилтийн хувь	50	Эхний хагас жилд: 70 Жилийн эцэст: 100	Архивын өрөө тасалгааг сайжруулах, архивын нэгжийн хадгалах хамгаалах орчин нөхцлийг сайжруулах журмаар 2025 оны 09 дүгээр сард "Төгс шимт оргил" ххк тай гэрээ байгуулан архивын нягтруулсан шүүгээ 15 ширхэг, Галын самбар 2ш, усны хувин 4ш, элсний хувин 4 ширхэгийг аван зориулалтын өрөөнд байрлуулан ашиглаж эхлэв.	100
2.1.10	Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	-	хэрэгжилтийн хувь	100	Эхний хагас жилд: 70 Жилийн эцэст: 100	Wifi OMNI антеныг 6 газар шинээр нэмж байрлуулсан ба Ховд хотын төв Ард Аюушийн талбайд 2, Хүүхэд, залуучуудын паркт 2, аймгийн ЗДТГ-т 1 антенн байруулж, 30-40 мегаватт хурдтайгаар, 350 метр зайнд үнэгүй интернэт үйлчилгээ үзүүлж байна. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хэрэгжүүлж буй Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрөөр Дарви сум Мөнгөн аяга багт үүрэн холбооны сүлжээний өргөтгөл хийх ажилд 150 сая төгрөгөөр “Тайжийн үр сад” ХХК үүрэн холбооны цамхаг, байр, хашаа байр барьж ашиглалтанд оруулж, үүрэн холбооны оператор компаниуд Мөнгөн аяга багт үйлчилгээ хүргэх боломжтой болсон. Мөн иргэдийн саналыг Засгийн газрын иргэд, олон нийтэй харилцах 11-11 төв ирсэн хүсэлт нийт -90, 7743-1111 утас ирсэн хүсэлт нийт 327 санал авч шийдвэрлэж ажиллаж байна. Мөн khovd.gov.mn сайт, khovdzdtg@khovd.gov.mn цахимаар санал болон өргөдөл гомдолоо илгээх нөхцлийг бүрдүүсэн. Албан хаагчиддаа ая тухтай орчинд ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд нийт 44 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж болон бусад шаардлагатай зүйлсийг авч өгсөн.	100
2.1.11	Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэж, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв болон 7043-1111 төвийн үйл ажиллагааг	-	Өргөдөл, гомдлын тоо - Шийдвэрлэлийн хувь	251 98%	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухайн жилд ирсэн өргөдөл	Үйлчилгээний нэгдсэн төв 2025 оны 11 дүгээр сарын 14-ний байдлаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар-3, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар-1, Улсын бүртгэлийн хэлтэс-3, Цахим шилжилт, үйлчилгээний хэлтэс -1, Цагдаагийн газар-1, нийт 9 мэргэжилтэн төрийн үйлчилгээг 10007 иргэнд түргэн шуурхай, хүртээмжтэйгээр хүргэн ажилласан байна. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.5-д заасны дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах 7043-	100

	сайжруулна.				гомдлы н тоо 100	1111 утасны үйл ажиллагааг сайжруулах, иргэн, захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, иргэдэд тулгамдаж буй асуудлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх зорилгоор Засаг даргын орлогч Л.Энбаярын баталсан хуваарийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн байгууллагын дарга, ажил хариуцсан мэргэжилтэнүүдийг "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-д 7 хоног бүрийн мягмар, пүрэв гаргуудад ажиллуулж байна. 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар 51 байгууллагын дарга, ажил хариуцсан мэргэжилтэнүүд 7043-1111 утсаар 435 санал хүсэлт, гомдлыг хүлээн авч холбогдох байгууллага албан тушаалтанаас утсаар тодруулга авч 309 иргэнд хариу зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан бол 126 иргэний санал хүсэлт, гомдлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн ажилласан байна. 7043-1111 утасны үйл ажиллагааг сайжруулах, иргэн, захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх ажлын хүрээнд "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийн иргэдийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах 7043-1111 утасыг 7743-1111 болгон өөрчилж санал хүсэлт, гомдол ихээр ирдэг байгууллагуудын утасыг 7743-1111 утсанд холбож иргэн, захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоог бэхжүүлэн иргэдэд тулгамдаж буй асуудлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. 2025 оны 11 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 7743-1111 утсанд 327 санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох байгууллага албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлүүлэн иргэнд хариу мэдэгдсэн байна.	
2.1.12	Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг тэлэн орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг хүртээмжтэй болгож, төрийн үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлнэ.	-	- Хэрэгжилтийн хувь	50мб	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 60мб	Цахим үйлчилгээний нэгдсэн портал <a href="https://erp.e-mongolia.mn">https://erp.e-mongolia.mn</a> системд 17 сум болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд, нийт 149 байгууллага холбогдож, албан хэрэг хөтлөлтийг нийт 1208 төрийн албан хаагч ашигласан байна. Мөн Цахимаар солилцсон албан бичгийн тоо 2025 оны 12 сарын 08-ны байдлаар 1502 ирсэн, 2087 явсан бичгийн цаг хугацаа алдалгүй цахимаар шийдвэрлээд байна. <a href="https://operator.e-mongolia.mn/auth/login">https://operator.e-mongolia.mn/auth/login</a> системээр дамжуулан 45 байгууллагын 453 төрлийн үйлчилгээ авах боломжыг дэд бүтэцээр хангаж ажиллаж байна. Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх "Digital first-D1" арга хэмжээний хүрээнд Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар болон Ховд аймаг дахь Цахим хөгжил инновац, харилцаа холбооны яамны цахим бодлого зохицуулалтын газар болон Ховд аймаг дахь Хур-дан төвийн ажилтан албан хаагчидтай хамтран цахим сургалтыг 3 удаа давхардсан тоогоор 216 албан	100

						хаагч, хамруулсан. ERP болон Gov.mn, control.e-mongolia.mn сайтуудыг Ховд аймгийн төрийн байгууллагын албан хаагчид болон сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар, Ховд аймгийн сумдын ЗДТГ-ын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд цахим, танхимийн сургалт зохион байгууллаж ажиллаж байна.	
2.1.13	www.intranet.gov.mn цахим системийг сум, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад нэвтрүүлнэ.	-	нэвтрүүлсэн сум, байгууллагын тоо	50	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 90	Аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2025 он гарснаар цахим үйлчилгээний нэгдсэн портал <a href="https://erp.e-mongolia.mn">https://erp.e-mongolia.mn</a> системд шилжсэн бөгөөд 17 сум болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд, нийт 149 байгууллага холбогдож, албан хэрэг хөтлөлтийг нийт 1208 төрийн албан хаагч ашигласан байна. Мөн Цахимаар солилцсон албан бичгийн тоо 2025 оны 12 сарын 08-ны байдлаар 1502 ирсэн, 2087 явсан бичгийн цаг хугацаа алдалгүй цахимаар шийдвэрлээд байна.	100
2.1.14	Аймгийн ЗДТГ болон сумдын ЗДТГ-ын интернетийн дотоод сүлжээний зохион байгуулалтыг сайжруулна.	-	Хурдны mb	40мб	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 40мб	Ховд аймгийн ЗДТГ-ын интернетийн хурдын нэмгэгдүүлэх дэд бүтэц суулгасан байгаа бөгөөд өндөр хурдны интернер хүлээж авах сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангаж CISCO төхөөрөмж, Wi-Fi төхөөрөмж нэмэлтээр байршуулж ажилтан албан хаагчдын интернет хэргэлээг бүрэн хангаж ажиллаж байна. Сумдын тамгын дарга нартай уулзаж сүлжээ өргөжүүлэх засвар үйлчилгээ авах сумын жагсаалт гаргаж дэд бүтэц суулгаж ажиллаж байна. Одоогоор Эрдэнэбүрэн, Буянт сумдад заавар зөвөлгөө өгч шаардагддаг тоног төхөөрөмж /свич, сүлжээний 5е утас, RJ45/ зэрэг тоног төхөөрөмжөөр хангаад байна. Цаашид үлдсэн сумдын сүлжээний хурдыг нэмэгдүүлэх боломжыг мобиком ххк хамтран ажиллаж, засвар хийх ажлыг шат дараалалтай хэрэгжүүлнэ.	100
2.1.15	Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим архив бүрдүүлж, баяжуулалт хийнэ.	-	Хэрэгжилтийн хувь	20	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 50	2025 онд 2024 оны хөтлөгдөж дуусаад архивд шилжүүлэн өгсөн байнга хадгалах хадгаламжийн нэгж 70, түр хадгалах хадгаламжийн нэгж 147, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж 12-ыг хүлээн авч, 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл Засаг дагын А захирамж 946, Б захирамж 62, Засаг дагын Тамгын газрын даргын А тушаал 127, Б тушаал 227-г khovd.gov.mn цахимд оруулан ажиллаж байна. Мөн архивын нэгжийг цахимжуулах зорилгоор зөврийн хард нэгийг авч 2010 оноос 2019 он хүртлэх ЗД захирамж, ТГ-ын даргын тушаалыг цахимжуулан хадгалаад байна.	100
2.1.16	Хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн хөтөч, ухуулагчдын үйл	-	Төлөвлөгөөний хэрэгжилти	Аймгийн хэмжээгээр 17	Эхний хагас жилд: -	Цэцэг сум, Зэрэг сум, Дарви, Ховд сум, Эрдэнэбүрэн сум, Мянгад сум, Буянт сумуудад сургалт зохион байгуулж 450 албан хаагч, иргэдийг хамруулан, Малчны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил	90

	ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, эрх		йн хувь,	сум, 22 байгууллагын нийт 50 эрх зүйн хөтөч бэлтгэсэн	Жилийн эцэст: Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, байгууллага, иргэд, эрх зүйн хөтөч, ухуулагчдыг мэргэжил арга зүйн туслалцаагаар ханган, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.	тод байдлын тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх зэрэг сэдвээр сургалт зохион байгуулав. 2. АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2025 оны 6 дугаар сард зохион байгуулсан авлигын эсрэг мэдлэг олгох цахим сургалтад аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнүүд, сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, тамгын газрын дарга нар нийт 70 албан хаагчийг хамруулсан. 3. Хэлтсийн ахлах мэргэжилтэн, ЗДТГ-ын ЭБАТ аймгийн төвийн Байгаль орчны газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын газар, Жаргалант сумын ЗДТГ, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Шүүхийн тамгын газарт "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Төрийн албан хаагчийн ёс зүй", Авлигын гэмт хэргийн ойлголт сэдвээр танхимын сургалтыг тус бүр байгууллага дээр нь 2025 онд зохион байгуулсан. Нийт 260 албан хаагч хамрагдсан. 4. АТГ-тай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд "Авлигатай тэмцэх газар", "АТГ-Олон нийтийн төв" цахим хуудсуудад тавигдаж байгаа шторк, богино хэмжээний кино, постеруудыг аймгийн албан ёсны сайт Khovd.gov.mn, Khovd.khural.mn, khovdnews.mn, newkhovd.mn болон аймгийн ЗДТГ-ын цахим хуудас, орон нутгийн Ховд телевиз, Олон ястны телевизүүдээр мөн "Эрх зүйн мэдээлэл сурталчилгаа" цахим хуудас зэрэг сошиаль сувгуудаар олон удаагийн давтамжтайгаар нийтэд сурталчилсан. 5. Төрийн албаны хүнд суртал, авлигаас урьдчилан сэргийлэх, E-Mongolia-с авах төрийн үйлчилгээг сурталчилсан 1 видео контентыг хийсэн. Эрх зүйн цахим сургалтын платформд (elearn.nli.gov.mn) 16 эрх зүйн хөтөч нар болон шинээр 2 эрх зүйн хөтчийг сургалтад хамруулсан.	
2.1.17	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, сургалт, нөлөөллийн ажлыг тогтмолжуулах	-	Сургалт сурталчилгааны тоо	Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг 3 удаа зохион байгуулсан.	Эхний хагас жилд: 4 Жилийн эцэст: Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг 5-с доошгүй удаа	АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2025 оны 6 дугаар сард зохион байгуулсан авлигын эсрэг мэдлэг олгох цахим сургалтад аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнүүд, сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, тамгын газрын дарга нар нийт 70 албан хаагчийг хамруулсан. 2. Хэлтсийн ахлах мэргэжилтэн, ЗДТГ-ын ЭБАТ аймгийн төвийн Байгаль орчны газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын газар, Жаргалант сумын ЗДТГ, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Шүүхийн тамгын газар, Хөгжимт драмын театр, Ус цаг уур орчны шинжилгээний төв, Ховд дулааны станц, Мал эмнэлгийн газарт "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Төрийн албан хаагчийн ёс зүй", Авлигын гэмт хэргийн ойлголт сэдвээр танхимын сургалтыг тус бүр байгууллага дээр нь 2025 онд зохион байгуулсан. Нийт 490 албан хаагч хамрагдсан. 3. АТГ-тай хамтран ажиллах	100

					зохион байгуул на.	төлөвлөгөөний хүрээнд "Авлигатай тэмцэх газар", "АТГ-Олон нийтийн төв" цахим хуудсуудад тавигдаж байгаа шторк, богино хэмжээний кино, постеруудыг аймгийн албан ёсны сайт Khovd.gov.mn, Khovd.khural.mn, khovdnews.mn, newkhovd.mn болон аймгийн ЗДТГ-ын цахим хуудас, "Ховд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл", орон нутгийн Ховд телевиз, Олон ястны телевизүүдээр мөн "Эрх зүйн мэдээлэл сурталчилгаа" цахим хуудас зэрэг сошиаль сувгуудаар олон удаагийн давтамжтайгаар нийтэд хүргэж сурталчилсан. 4. Төрийн албаны хүнд суртал, авлигаас урьдчилан сэргийлэх, E-Mongolia-с авах төрийн үйлчилгээг сурталчилсан 1 видео контентыг хийсэн.	
2.1.18	Хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн хөтөч, ухуулагчдын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тасралтгүй зохион байгуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, Мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн байдал, сургалт сурталчилгааны тоо	Аймгийн хэмжээгээр 17 сум, 22 байгууллагын нийт 50 эрх зүйн хөтөч бэлтгэсэн.	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, байгууллага, иргэд, эрх зүйн хөтөч, ухуулагчдыг мэргэжил арга зүйн туслалцаагаар ханган, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.	1. Цэцэг сум, Зэрэг сум, Дарви, Ховд сум, Эрдэнэбүрэн сум, Мянгад сум, Буянт сумуудад сургалт зохион байгуулж 450 албан хаагч, иргэдийг хамруулан, Малчны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх зэрэг сэдвээр сургалт зохион байгуулав. 2. АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2025 оны 6 дугаар сард зохион байгуулсан авлигын эсрэг мэдлэг олгох цахим сургалтад аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дараг, ахлах мэргэжилтнүүд, сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, тамгын газрын дарга нар нийт 70 албан хаагчийг хамруулсан. 3. Хэлтсийн ахлах мэргэжилтэн, ЗДТГ-ын ЭБАТ аймгийн төвийн Байгаль орчны газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын газар, Жаргалант сумын ЗДТГ, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Шүүхийн тамгын газарт "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Төрийн албан хаагчийн ёс зүй", Авлигын гэмт хэргийн ойлголт сэдвээр танхимын сургалтыг тус бүр байгууллага дээр нь 2025 онд зохион ажиллах төлөвлөгөөний хүрээнд "Авлигатай тэмцэх газар", "АТГ-Олон нийтийн төв" цахим хуудсуудад тавигдаж байгаа шторк, богино хэмжээний кино, постеруудыг аймгийн албан ёсны сайт Khovd.gov.mn, Khovd.khural.mn, khovdnews.mn, newkhovd.mn болон аймгийн ЗДТГ-ын цахим хуудас, , орон нутгийн Ховд телевиз, Олон ястны телевизүүдээр мөн "Эрх зүйн мэдээлэл сурталчилгаа" цахим хуудас зэрэг сошиаль сувгуудаар олон удаагийн давтамжтайгаар нийтэд сурталчилсан. 5. Төрийн албаны хүнд суртал, авлигаас урьдчилан сэргийлэх, E-Mongolia-с авах төрийн үйлчилгээг сурталчилсан 1 видео контентыг хийсэн. Эрх зүйн цахим сургалтын платформд (elearn.nli.gov.mn) 16 эрх зүйн хөтөч нар болон шинээр 2 эрх зүйн хөтчийг сургалтад хамруулсан.	90

2.1.19	Байгууллага иргэдэд архивын баримтаар үйлчилгээ үзүүлнэ.	-	цахимаар үзүүлсэн үйлчилгээн ий тоо	2024 онд архивын 6 төрлийн лавлагаа г 1089 иргэнд олгож үйлчилсэн.	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Архивын 6 төрлийн лавлагаагаар хүсэлт гаргасан хүн бүрт үйлчилнэ.	<p>e_archives.gov.mn-ээс 110 хүнд лавлагаа олгогдсноос хөдөлмөр эрхлэлтийн 67, цалингийн 3, малын тооллогын 5, хүн амын тооллого -35 хүнд лавлагаа олгогдсон байна.</p> <p>Ховд аймгийн Жаргалант сумын 240 жилийн ойн зориулан сэтгүүлч, зохиолч г.Цагаан аймгийн Засаг даргын Тамгын газрын 1930-1950 оны 21 ширхэг хадгаламжийн нэгж, аймгийн цуглуулагын фото зургаас 25 ширхэг зургийг уншлагаар ашигласан.</p> <p>2025 оны 2 хөмрөгийн 2 дансны 54 хадгаламжийн нэгжийн 2794 ширхэг хуудсыг цахим хэлбэрт шилжүүлсэн.</p>	100
2.1.20	Үнэлгээ, мониторингийн тайлан мэдээ, санал, дүгнэлт, зөвлөмж, мэдээ мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, аймгийн веб сайт, мэдээлэл, сурталчилгааны самбарт тухай бүрт нь ил тод мэдээлэх	-	Үнэлгээ, мониторингийн талаарх мэдээллийг шинэчилсэн тоо, цахим хуудсанд оруулсан мэдээллийн тоо	Үнэлгээ, мониторингийн талаарх мэдээллийг шинэчилсэн тоо, цахим хуудсанд оруулсан мэдээллийн тоо	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Мэдээллийн самбарт байршуулсан мэдээ, мэдээллийг улирал тутам шинэчилж, шаардлагатай тохиолдолд үнэлгээ, мониторингийн талаарх мэдээ,	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн бүтэц, бүрэлдэхүүн болон холбогдох мэдээллийг мэдээллийн самбар болон аймгийн цахим сайтад байршуулсан бөгөөд, Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх болон тус хэлтсийн талаарх мэдээ, мэдээлэл өөрчлөгдөх бүрт мэдээллийн самбарыг шинэчлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 2 удаа мэдээллийн самбар дэх мэдээллийг шинэчилсэн бөгөөд шаардлагатай тохиолдолд удирдлага, албан хаагчид болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн талаарх дүн, тайлан мэдээг аймгийн цахим сайтад байршуулсан болно.</p>	100

					мэдээллийг аймгийн албан ёсны цахим хуудсанд байршуулах, иргэд олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх.	
--	--	--	--	--	---	--

**2.2. БАГШ, СУРАГЧДЫН СУРЧ, ХӨГЖИХ ОРЧНЫГ САЙЖРУУЛЖ, СУРГАЛТЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:**

2.2.1	Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгоно.	-	Хангагдсан цэцэрлэг, Сургууль, Дотуур байрны тоо	13 23 13	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 16 27 15	Энэ оны 9 сард улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Манхан, Дөргөн сумын сургууль, цэцэрлэг, дотуур байр, Булган сумын 1-р цэцэрлэг, Булган сумын 2-р сургуулийн дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих 4-р ээлжийн ажил хийгдэж улсын комисс хүлээн авч байнгын ашиглалтад орууллаа. Ингэснээр Ховд аймгийн 16 сум орчин үеийн ариун цэврийн байгууламжид бүрэн холбогдлоо.	100
2.2.2	Аймгийн төв болон хүн ам нягт суурьшсан сумдын сургуулийг автобустай болгож, сурагчид сургуульдаа аюулгүй, тав тухтай ирж, очих нөхцөл бүрдүүлэн хүүхдийн аюулгүй байдлыг сайжруулж, эцэг эхчүүдийн ачааллыг бууруулна.	-	Хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 30	Орон нутгийн хөгжлийн сангийн 590,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн төв болон хүн ам нягт суурьшсан сумдын сургуулийг автобустай болгож, сурагчид сургуульдаа аюулгүй, тав тухтай ирж, очих нөхцөл бүрдүүлэн хүүхдийн аюулгүй байдлыг сайжруулж, эцэг эхчүүдийн ачааллыг бууруулах зорилгоор 3 ширхэг хүүхдийн автобусыг авч, 3 чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2024 оноос эхлэн Жаргалан сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлж, үйл ажиллагааны зардлыг хариуцан жилд цалин 44640,0 мянган төгрөг, шатахуун зардалд 37638,5 мянган төгрөг, түрээсийн зардал 25500,0, сэлбэг 3208,0 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэн ажиллуулж байна.	100
2.2.3	Математик, англи хэлний мэдлэг, чадвар	-	Сурагчийн тоо	10414 7709	Эхний хагас	Математикийн хичээлийг дэмжих Эдүтэн цахим платфорыг 1-9 дүгээр ангид хэрэгжүүлж байна. Ховд аймгийн 25 сургуулийн 1-р	100

	олгох Eduten, Pearson болон бусад цахим платформуудын ашиглалтыг сайжруулж, суралцагчдын математик, англи хэлний мэдлэгийг гүнзгийрүүлж, боловсролын ялгаатай байдлыг арилгана.				жилд: - Жилийн эцэст: 10414 7709	ангийн 2078, 2-р ангийн 2121, 3-р ангийн 2298, 4-р ангийн 2337, 5-р ангийн 2137, нийт бага ангийн 10971 хүүхэд, 6-р ангийн 1879, 7-р ангийн 1708, 8-р ангийн 1432, 9-р ангийн 1214 нийт суурь боловсролын 6233 суралцагч суралцаж байна. Бага боловсролд суралцагчид 9 дүгээр сараас эхлэн тайлант хугацаанд хүртэл дунджаар 4,9 цаг цахим системд ажиллаж байгааг тооцвол дунджаар 7 хоногт 29 минутыг цахим сургалтад зарцуулж байна. Бага ангийн нийт сурагчдын нарийвчлал 84,51 суурь боловсролын хувьд 67,03 хувь байна. Pearson хөтөлбөрт 3-8 дугаар ангийн 11998, Цаст алтай,Мянгад сумын ерөнхий боловсролын сургуулийн 9-12 ангийн 683 сурагчид хамрагдаж байна. Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 9, 10 дугаар ангийн 3041 сурагчдын 2024-2025 оны хичээлийн жилд “suraad.mn” математик сургалтын цахим платформын ашиглалтын зардалд 106,435,000 төгрөгийг “Ховдын ирээдүй” төсөл арга хэмжээнээс шийдвэрлэсэн.	
2.2.4	Ерөнхий боловсролын сургуулийн бүх сурагчдыг үдийн хоол хөтөлбөрт бүрэн хамруулж, хоолны шим тэжээлийг сайжруулан, сурагчдын эрүүл мэнд, өсөлт, хөгжилд эерэг нөлөө үзүүлэх боломж бүрдүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	47.7	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 60	2025 онд аймгийн 34 цэцэрлэг 7272, ерөнхий боловсролын 24 сургуулийн 10157 суралцагч үдийн хоолонд хамрагдаж байна. Үүнээс 56 байгууллага стандартын шаардлага хангасан гал тогоонд хоол үйлдвэрлэл явуулж байна. 2 сургууль зориулалтын бус гал тогоотой байна. Цэцэрлэгт 73 тогооч, 21 туслах ажилтан, ЕБС-ийн үдийн хоолонд 54 тогооч, 30 туслах ажилтан, Дотуур байрын 39 тогооч, 18 туслах ажилтан, нийт 229 хүн ажиллаж байна. Хүнсний хангамж, нөөцийг тендерт шалгарсан аж ахуйн нэгжээс авч, стандартын дагуу хоол үйлдвэрлэл үйлчилгээг хэрэгжүүлж байна. Ерөнхий боловсролын 21 сургууль эцэг эхийн дэмжлэгтэйгээр ахлах, дунд ангийн 8250 гаруй сурагчдыг үдийн хоолонд хамруулсан. 9-н сургууль ARTA системийн карт нээж ашиглаж байна. Дарви сумын ЕБС-ийн ахлах дунд ангийн 340 хүүхдийн хоолны зардал 41.0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн сангаасаа шийдвэрлэж, Цэцэг сумын ЕБС-ийн 363 сурагчийн хоолны зардлын 25 хувийг орон нутгийн хөгжлийн сангаасаа 75 хувийг эцэг эх асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэсэн байна.	100
2.2.5	Манхан, Мөнххайрхан сумын сургуулийн барилгыг өргөтгөж, Жаргалант сумын 1, 3, Прогресс, Мөст, Эрдэнэбүрэн сумын сургуулийн барилга, Жаргалант сумын	2326,9 3237,4	Хэрэгжилтийн хувь	30	Эхний хагас жилд: 50 Жилийн эцэст: 100	2025 онд он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнээс Манхан сумын сургууль /240 суудал/, Манхан сумын дотуур байр /150 ор/, Мөнххайрхан сумын сургууль /160 суудал/ -ийн шинэ барилга ашиглалтад орууллаа. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар тайлант 2025 онд 4 сургууль, 4 дотуур байрыг 3,4 тэрбум төгрөгөөр иж бүрэн болон хэсэгчилсэн байдлаар засварлаж улсын комисс хүлээн авч, сургалтын лаа.орчинг сайжрууллаа.	100

	ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн спорт заалны барилгыг засварлана.						
2.2.6	Жаргалант сумын 2, 4 ,6 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, 3, 5, 7, 12, Буянт, Дөргөн сумын цэцэрлэгийн барилгыг засварлаж, 1, 15, 16 дугаар цэцэрлэгт сургалтын орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	1614,7 ОНХО 3933,7 УТ	Хэрэгжилтийн хувь	30	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 80	2025 онд он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнээс Жаргалант сумын Бичигт багийн цэцэрлэг /150 ор/, 4-р цэцэрлэг /150 ор/ зэрэг 2 шинэ барилга ашиглалтад орууллаа. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар тайлант 2025 онд 8 цэцэрлэгийг иж бүрэн болон хэсэгчилсэн байдлаар засварлаж улсын комисс хүлээн авч, сургалтын орчинг сайжрууллаа.	100
2.2.7	МУИС-ийн ББС-ийн оюутны байр, Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны барилгыг барьж, ББС-ийн оюутны 2 дугаар байр, Алтай, Ховд, Үенч, Цэцэг сумыг сургуулийн дотуур байрны барилгыг засварлана.	- 1259,0 ОНХО 5125,3 УТ	Хэрэгжилтийн хувь	10	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 60	2025 онд он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнээс Манхан сумын дотуур байр /150 ор/, -ны шинэ барилга ашиглалтад оруулж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар тайлант 2025 онд 4 дотуур байрыг иж бүрэн болон хэсэгчилсэн байдлаар засварлаж улсын комисс хүлээн авч, сургалтын орчинг сайжрууллаа.	100
2.2.8	Хөгжил политехник коллежийн барилга, спорт заалыг засварлана.	-269,4 ОНХО	Хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Аймгийн орон нутгийн 220,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хөгжил политехник коллежийн спорт заалны барилгыг засварласан мөн тус сургуулийн сан техникийг 68,1 сая төгрөгөөр засварласан.	100
2.2.9	Хотын нийтийн тээврийн автобусны чиглэл, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэгүй зорчих нөхцөлөөр хангана.	95.0 ОНХО	Хамрагдсан иргэдийн тоо /давхардсан тоогоор/	200	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 2500	Хотын нийтийн тээврийн хэрэгслээр 8177 гаруй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд 39508 үнэгүй зорчих эрхийн үнэмлэх олгож "Бат хөсөгтөн" автобус баазтай гэрээ байгуулан 49.2 гаруй сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн 590,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн төв болон хүн ам нягт суурьшсан сумдын сургуулийг автобустай болгож, сурагчид сургуульдаа аюулгүй, тав тухтай ирж, очих нөхцөл бүрдүүлэн хүүхдийн аюулгүй байдлыг сайжруулж,	100

						эцэг эхчүүдийн ачааллыг бууруулах зорилгоор 3 ширхэг хүүхдийн автобусыг авч, 3 чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2024 оноос эхлэн Жаргалан сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлж, үйл ажиллагааны зардлыг хариуцан жилд цалин 44640,0 мянган төгрөг, шатахуун зардалд 37638,5 мянган төгрөг, түрээсийн зардал 25500,0, сэлбэг 3208,0 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэн ажиллуулж байна.	
2.2.10	Бүтэн өнчин хүүхдийн “Гэрэлт ирээдүй” хадгаламжийг үргэлжлүүлнэ	6.0 ЗД-данс	Бүтэн өнчин хүүхдийн тоо	44	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 44-60	Аймгийн Засаг даргын бүтэн өнчин хүүхдэд сар бүр олгодог тэтгэмж 2014 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн. Гэрэлт-Ирээдүй хадгаламжид 2024 онд 44 хүүхэд хамрагдсан бол тус онд шинээр бүтэн өнчин 13 хүүхдийн оруулахаар материалыг хүлээн авлаа. Мөн БНХАУ-аас Монгол улсад суугаа Элчин сайд Шэнь Миньжуань Ховд аймагт ажиллах үеэрээ дээрхи хүүхдүүдэд нэрэмжит тэтгэлгээ гардуулсан бөгөөд нийт 22,0 сая төгрөгийн тэтгэлэг олгосон болно.	100
2.2.11	Гэр бүл хөгжлийн төвийг байгуулна.	1300.0 УТ	Барилгын гүйцэтгэлийн хувь	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 50	Гэр бүл хөгжлийн цогц төвийг улсын төсвийн 3,290.10 төгрөгийн санхүүжилтээр Толхын ойл ХХК барьж барилгын гүйцэтгэл 80 хувьтай байна. 2026 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.	100
2.2.12	Сум бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, хөгжил, хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэнэ.	-	хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай болсон сумдын тоо	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 17	Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоолоор аймгийн 12 баг, 17 суманд нийт 30 хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтныг 2025 оны гуравдугаар сараас эхлэн ажиллуулж эхэлснээр далд хэлбэрийн хүчирхийллийг илрүүлэх, шийдвэрлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар сайжирч, үр нөлөө мэдэгдэхүйц дээшилж, хүүхдийн эрхийн зөрчил өнгөрсөн оны мөн үетэй харицуулахад 28 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Шинээр томилогдсон хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнуудад 30 таблелт, аюулгүйн багц, 30 зөөврийн компьютерийн дэмжлэг үзүүлж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан.	100
2.2.13	Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох, нөлөөллийн арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж түр хамгаалах байрны	40.0	Нөлөөллийн арга хэмжээний тоо	3	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 6	Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шуурхай тусламж хариу үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Аз жаргалтай гэр бүл эвент”, “Эмэгтэйчүүдийн дуу хоолой”, “Ажлын байран дахь тогтвортой сэтгэл зүй”, “Баг бүрдүүлэлт ба манлайлал”, “Харилцаа хандлага ба хувь хүний хөгжил”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль”, “Гэр бүл дэх хүүхэд хамгаалал” зэрэг 80 удаагийн соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд 12000 иргэн хамрагдсан бөгөөд	100

	тогтвортой үйл ажиллагааг хангана.					зорилтот бүлгийн хүн амын 13.1 хувьд хүрч ажилласан байна.	
2.2.14	Хүүхдийн Баянбулаг зуслангийн үйл ажиллагааг тогтмолжуулж, стандартад нийцүүлэн тохижуулна.	200.0 ОНХС	Хэрэгжилтийн хувь	50	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 80	Хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр 28 арга хэмжээ зохион байгуулж, 8700 гаруй хүүхэд хамрагдаж, нийт хүүхдийн 24.2 хувьд хүрч ажилласан байна. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дэргэдэх хүүхэд хөгжүүлэх 11 төрлийн дугуйланд 912 хүүхэд хамрагдан өөрийгөө хөгжүүлснээс хөнгөлөлттэй нөхцөлөөр 15 хүүхэд, үнэ төлбөргүй 10 хүүхэд суралцлаа. Хүүхэд хөгжүүлэх чиглэлээр хичээллэж байгаа секц дугуйлан, суралцаж буй хүүхдийн чиглэлээр мэдээллийн сан үүсгэн ажиллалаа. Аймгийн хэмжээнд хүүхэд хөгжүүлэх 256 дугуйлан секц үйл ажиллагаагаа явуулж хүүхэд хөгжүүлэх дугуйланд 8000 гаруй хүүхэд суралцаж байна. Дугуйлангийн хүртээмжийг нэмэгдүүлж хүүхдийн ордны дэргэд шинээр Төгөлдөр хуур, драмын дугуйлангууд элсэлтээ авч байна. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрийг тасалдуулахгүйн тулд орон нутгийн амралтын бааз аймгийн Дуут сумын Цагаан бургас багт байрлах “Нэвтийн амралтын газар”-т хүүхдүүдийг амраах саналыг орон нутгийн удирдлагуудад хүргүүлэн шийдвэрлүүлж, Хүүхдийн зуслангийн 2025 оны зуны 4 ээлжинд 360 хүүхдийг зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан. Баруун бүсийн хүүхдийн зусланг MNS 5633:2023-т стандартад нийцүүлэн ТЭЗҮ боловсруулахаар 2026 оны төсөвт 200.0 сая төгрөгийг тусгуулаад байна.	100
2.2.15	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлнэ.	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, хүүхэд зэрэг хүн амын бүлэгт ээлтэй, хүртээмжтэй болгосон иргэний барилга байгууламж	3	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 8	Бүх шатны боловсролын байгууллагад тэгш хамран сургах боловсролыг хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын 25 сургууль, 33 цэцэрлэгт тус бүр 2 ширхэг тохируулагд ширээ сандлыг орон нутгийн төсвийн 122.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, сургалтын байгууллагуудад олголоо. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах боломжийг бүрдүүлэхээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 25 сургууль, 33 цэцэрлэг байгаа ба хүртээмжийн үнэлгээгээр 45,2 хувьтай үнэлэгдсэн байна. 2026 онд аймгийн төвийн сургууль, цэцэрлэгийг 2027 онд сумдын сургууль цэцэрлэгийн орчныг стандартад нийцүүлж, хүртээмжийг 90-с дээш хувьд хүргэж, тохируулгат орчныг бүрдүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахаар төлөвлөж байна.	100
2.2.16	Ахмадын ордны барилгад урсгал засвар хийнэ.	50.0 ОНХС	Засварын тоо	1	Эхний хагас жилд: -	Ахмадын ордны барилгад урсгал засвар хийхээр 50.0 сая төгрөг орон нутгийн төсөвт тусгасан боловч төсөв санхүүгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан тодотголоор хасагдсан.	50

					Жилийн эцэст: 1		
<b>2.3. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЖ, ИРГЭДЭД ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВШЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:</b>							
2.3.1	Монголын Хүүхдийн спортын их наадмын шигшээ тэмцээнд аймгийн шигшээ багийг амжилттай оролцуулна.	85.0	Оролцсон тамирчдын тоо өссөн байна.	168	Эхний хагас жилд: 170 Жилийн эцэст: 180	Монголын хүүхдийн спортын зуны 8 дугаар их наадам 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 06 дугаар 06-ний өдрийг хүртэлх хугацаанд Улаанбаатар хотноо зохион байгуулагдлаа. Тус наадамд Ховд аймгаас спортын 14 төрлөөр 175 тамирчин 10 дасгалжуулагчийн хамт оролцож волейболын шигшээ багийн охидын баг хүрэл медалийн эзэд боллоо. Нийтдээ 30 баг өрсөлдсөнөөс багийн дүнгээр 3 дугаар байр эзэллээ. Ганцаарчилсан төрөлд Байт харвааны шигшээ багийн тамирчин спортын дэд мастер Г.Хатанбүүвэй Хүрэл медаль, Тусгай хөнгөн атлетикийн тамирчин Н.Нинжин L100м-Мөнгөн медаль, L200м-Мөнгөн медаль, Таеквондогийн шигшээ багийн тамирчин Мөнхбаатарын Маралмаа охидын 55 кг жинд мөнгөн медаль, Лхагвадоржийн Тогтохтөр -78 кг жинд хүрэл медаль, Ган-Очирын Уянга охидын 49 кг жинд хүрэл медаль, Жюү жицү төрөлд Мөнгөнбаяр мөнгөн медаль, Чөлөөт бөхийн 43 Кг жинд Х.Отгонцэцэг Хүрэл медаль, охидын 43 кг жинд Л.Мөнгөнсүвд Алтан медаль тус тус хүртсэн амжилт үзүүллээ. Нийт 17 хүрэл, 4 мөнгөн медаль, 1 Алтан медаль хүртсэн байна. Мөн Сагсан бөмбөгийн 5х5 төрөлд эмэгтэй баг 21 аймаг, 9 дүүргийн нийт 30 багаас шигшээ 6, Хөлбөмбөгийн эрэгтэй баг 30 багаас шигшээ 8-д шалгарсан амжилттай оролцлоо.	100
2.3.2	Монголын Бүх ард түмний спортын их наадмын шигшээ тэмцээнд аймгийн шигшээ багийг амжилттай оролцуулах	68.0	Оролцсон тамирчдын тоо	123	Эхний хагас жилд: 130 Жилийн эцэст: 135	Монголын бүх ард түмний XVI дугаар их наадамд Ховд аймгийн баг, тамирчид спортын 13 төрлөөр нийт 169 тамирчин, дасгалжуулагчийн бүрэлдэхүүнтэй оролцож 2 алт , 3 мөнгө , 7 хүрэл медаль хүртэж, багийн дүнгээр 11 дүгээр байр эзэлсэн байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын 3 төрөлд оролцож, 2 мөнгөн медаль хүртсэн амжилттай оролцлоо.	100
2.3.3	Өсвөр үеийн Улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа зохион байгуулах	75.0	Арга хэмжээний тоо	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1	Спортын холбоо, клубын үйл ажиллагааг дэмжих зорилгоор аймгийн Таеквондогийн холбоотой хамтран Таеквондогийн бага насны Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулав. Тэмцээнд 26 багийн 621 тамирчид оролцсоноос Ховд аймгийн тамирчид 9 алт, 6 мөнгө, 4 хүрэл нийт 19 медаль хүртэж багийн дүнгээр III дугаар байранд шалгарсан. Монгол улсын 21 аймгийн өсвөрийн шатарчдын “Эвлэл -21” тэмцээнд 17 аймгийн 400 гаруй тамирчид өрсөлдсөнөөс Ховд аймаг тэргүүн байранд шалгарсан байна. ОУХМ Лхамжавын Баатархүрээгийн нэрэмжит Ахмадын	100

						Волейболын Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Булган суманд зохион байгуулж, тэмцээнд 65 багийн 800 орчим тамирчид оролцлоо. Ховд аймгаас 20 багийн 250 гаруй тамирчин аймгаа төлөөлөн оролцсоноос ахмадын 3 насны ангилалд 21 тамирчин мөнгөн медаль хүртлээ. “ХУРДАН СУР-2025” Баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Завхан аймгийн ахлах ангийн 300 гаруй сурагчид оролцоо. “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж буюу дрон” жолоодлого, цахим спорт, уран илтгэлийн төрлөөр анх удаа Ховд аймагт зохион байгуулагдсан нь онцлог байлаа.	
2.3.4	Нийтийн биеийн тамирын “Цаг гаргая аян”, “Өглөөлөг Ховдчууд” аянг зохион байгуулах	15.0	Хамрагдагсдын тоо хувиар	25 хувь	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Нийт хүн амын 30 хувийг хамруул на.	“Цаг гаргая” “Бие эрүүл мэнддээ цаг гаргая -Өглөөлөг Ховдчууд” аяны хүрээнд 11 арга хэмжээг зохион байгуулсан байна. Арга хэмжээнүүдэд 17 сумын иргэд, 90 гаруй төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдын төлөөлөл, ЕБС-иудын сурагчид, СӨБ-ийн багачуудын төлөөлөл давхардсан тоогоор 69.295 мянган хүн өглөөний дасгал, алхалт, гүйлт, дугуй, шугман бүжиг, хийн дасгал, ажлын байрны Түмэн дасгал, 5 цул эрхтний дасгалд тогтмол хамрагдаж, ажилтан албан хаагчид ажлын байрны дасгалуудыг хийж хэвшсэн. Аймгийн Нийт хүн амын 60 гаруй хувь нь давхардсан тоогоор дасгал хөдөлгөөнд хамрагдсан үзүүлэлттэй байгаа бөгөөд хамрагдагчдын тоо цаашид өсөн нэмэгдэх хандлагатай байна.	100
2.3.5	Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын төрлүүдээр зохион байгуулах	23.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	22	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 23	2025 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 14 төрлөөр 65 Биеийн тамир, спортын арга хэмжээ, Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж нийт 16000 гаруй тамирчин давхардсан тоогоор оролцсон байна. Бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 7 төрлөөр оролцож Алт 57, Мөнгө 82, Хүрэл 67 нийт 205 медаль хүртсэн байна. Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 15 төрөлд Алт 21, мөнгө 24, Хүрэл 148 нийт 193 медаль хүртэж Бүс, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс нийт 398 медаль хүртсэн амжилттай байна. Ховд аймгийн хэмжээнд секц дугуйланд 5000 гаруй өсвөр үеийн хүүхдүүд хичээллэж байна.	100
2.3.6	Спортын ордны засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.	756.0	Хэрэгжилтийн хувь	30	Эхний хагас жилд: 50 Жилийн эцэст: 100	Оргил жи трейд ХХК нь 720 сая төгрөгийн төсөвт өртөгөөр Биеийн тамир, спортын газрын гадна засварын гадна фасадны ажлыг хийж гүйцэтгэлээ.	100
2.3.7	Биеийн тамирын	150.0	Хэрэгжилти	0	Эхний	Мянгад сумын Ерөнхий боловсролын сургуулийн гадна талбайд	50

	талбайн засвар, тохижилт/Мянгад сум/		йн хувь		хагас жилд: 50 Жилийн эцэст: 100	тохижилтын ажил хийгдэхээр тендер шалгаруулалт зарлагдсан байна.	
<b>ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>							
<b>3.1. БАТЛАН ХАМГААЛАХЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, СУРТАЛЧЛАХ, СЭРГЭЛТТ БЭЛТГЭЛИЙГ ТАСРАЛТГҮЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДАД ЦЭРЭГ ЭХ ОРОНЧ ҮНДЭСНИЙ ҮЗЭЛ ТӨЛӨВШҮҮЭХ, ИРГЭН ЦЭРГИЙН ХАРИЛЦААГ БЭХЖҮҮЛЭХ” – ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:</b>							
3.1.1	Цэрэг бүртгэл, цэрэг халах, татах арга хэмжээг зохион байгуулах	50,5 сая	Цэргийн бүртгэл, цэрэг халах, татах арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	90%	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 95%	Цэргийн бүртгэл хуулийн хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/142 дугаар захирамжийн дагуу зохион байгуулагдсан. Цэргийн бүртгэл аймгийн хэмжээнд 80,8 хувьтай явагдсан. Ээлжит цэрэг татлага салбарын үйл ажиллагааг сурталчилж цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан. Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгсөн хяналтын тоог бүрэн биелүүлсэн	100
3.1.2	Аймгийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, сургалт явуулах	40 сая	Тодотгол хийж, сургалт явуулсан тоо	2/2	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 2/2	Аймгийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үүднээс томилгоот нэгжийн тодотголыг сумдын ЗДТГ-ын дарга нартай 02 дугаар сард хийсэн. Томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний болон томилгоот иргэдийн сургалтыг 09 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулсан.	100
3.1.3	Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймаг, орон нутгийн ард иргэдэд сурталчлан таниулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах	40 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо	5/9000	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 6/10000	Батлан хамгаалах яамнаас 2025 оныг "Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил" болгон зарласантай холбогдуулан иргэдэд эх оронч үзэл төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэхэд чиглэсэн ажил арга хэмжээг зохион байгуулж ирсэн. Энэ хүрээнд салбарын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчилж ажилласан. Тайлант хугацаанд салбарын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр 20 ажил арга хэмжээг зохион байгуулсан байна	100
3.1.4	Улсын дайчилгааны төлөвлөгөөний дагуу сумдын дайчилгааны төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх, цэргийн дайчилгааны	БХЯ, Орон нутгийн төсвөөс	Тодотгол хийж, сургалт явуулсан тоо	2/1	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 2/2	Аймгийн Улсын дайчилгааны төлөвлөгөөг батлуулсантай холбогдуулан сумдад дайчилгааны даалгавар тогтоож өгсөн. Үүний дагуу сумдын Улсын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах ажил хийгдсэн. Төлөвлөгөөний төслийг Батлан хамгаалах яаманд хянуулах ажил хийгдэж байна.	90

	бэлтгэл үүрэгтний сургалт явуулах						
3.1.5	Ард иргэдийг Батлан хамгаалах салбарын мэдээ мэдээллээр хангах, тэдний өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	-	Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн тоо	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 300	Тайлант хугацаант тус Цэргийн штабаас ард иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд анхаарч ажилласан. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.	100
3.1.6	Мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хангаж ажиллана	-	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Тайлант хугацаанд төрийн болон албаны нууц хадгалалт хамгаалалтад анхаарч нууцын журмыг мөрдлөг болгон ажилласан. Цэргийн штабаас зохион байгуулсан сургалт, спортын уралдаан тэмцээний үед хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс тухай бүрт нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж ажилласан.	100
3.1.7	Хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдыг эргэх, тэдний ар гэрт дэмжлэг үзүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн анги, салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	20 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 4	Тус аймгаас хугацаат цэргийн албанд татагдан алба хааж байгаа дайчдын үйл ажиллагаатай танилцах, тэдний ар гэрт дэмжлэг үзүүлэх ажлыг 02, 03 дугаар саруудад зохион байгуулсан. Арга хэмжээнд аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар оролцсон. Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн анги салбарт дэмжлэг үзүүлж үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг дээшлүүлэхэд анхаарч ажилласан	100
3.1.8	Хяналт шалгалтын ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх	-	Шалгалт, албан шаардлага, зөвлөмжийн тоо	5 шалгалт хийж, 7 зөвлөмж, албан шаардлага	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулна.	Салбарын хяналтын газраас баталсан удирдамжийн дагуу нийт 7 хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 84 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. Салбарын хяналтын газраас ирүүлсэн удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх шалгалтыг тухай бүр зохион байгуулж байна. Хяналт шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Илэрсэн зөрчлийн арилгалт 70 хувьтай байна.	70

3.2. “ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАСРАЛТГҮЙ ЯВУУЛЖ, ОРОН НУТГИЙН ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ”- ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

3.2.1	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;	-	Хэрэгжилтийн хувь	90	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 92	<p>“Алсын хараа-2050”, Шинэ сэргэлтийн бодлогын Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, мэргэшсэн, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад төрийн үйлчилгээний үндэсний стандарт нэвтрүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд соёлтой, шуурхай, хүнд сурталгүй хүргэхэд анхаарч, хүртээмжийг сайжруулан чанарын шинэ шатанд гаргах зорилт дэвшүүлж, Төрийн албаны тухай хууль тогтоомж, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Салбар зөвлөлийн ажиллах, үйл ажиллагааг дүгнэх журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллалаа.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ХНУМТ цахим системд мэдээлэл оруулахдаа гаргасан алдааг засуулах, хэрхэн мэдээллээ шинэчлэх талаар сум, байгууллагын удирдлагууд, холбогдох албан хаагчдад 3 удаагийн сургалт зохион байгуулж, зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулж ажиллав.</li> <li>- ТАЗ-ийн даргын 2025 оны 02 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Ховд аймгийн төрийн 112 байгууллагын 3796 төрийн албан хаагчийн Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилттэй танилцан хяналт, шалгалт хийж, албан хаагчдад төрийн албаны шинэтгэлийн талаар мэдээлэл, сургалт хийж, тулгамдсан асуудлаар санал солилцон, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</li> <li>- ХНУМТ цахим системд 145 байгууллагын 4725 албан тушаалд ажиллаж буй 5416 албан хаагчаас 3703 албан хаагч мэдээллээ бүрэн шинэчилж, баталгаажуулалт 68.4 хувьтай байна.</li> <li>- “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” бүсийн зөвлөгөөн хийх ажлын хэсэгтэй хамтран 2025 оны 05 дугаар сард баруун бүсийн зөвлөгөөнийг хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулж, Ховд, Увс, Говь-Алтай, Завхан, Баян-Өлгий аймгийн төлөөлөл 700 гаруй төрийн албан хаагчид хамрагдав. Баруун бүсийн зөвлөгөөн нь бүс нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж, шийдлийг хамтдаа эрэлхийлэн зөвлөгөөний үеэр хөндөгдсөн асуудлыг нэгтгэж, хуулийн шинэчлэлд тусгаж ажиллахаараа онцлог болсон юм.</li> <li>- Салбар зөвлөлөөс хариуцан 200 гаруй мэдээ, мэдээлэл бэлтгэн Монголын үндэсний телевиз, Ховд телевиз,</li> </ul>	100
-------	--	---	-------------------	----	--------------------------------------	---	-----

						<p><a href="http://khovdnews.mn/?id=207900">http://khovdnews.mn/?id=207900</a>, аймгийн албан ёсны <a href="http://khovd.gov.mn/">http://khovd.gov.mn/</a> цахим хуудас болон аймгийн Засаг даргын Тамгын газрын <a href="https://www.facebook.com/khovdzdtg">https://www.facebook.com/khovdzdtg</a>, Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн <a href="https://www.facebook.com/">https://www.facebook.com/</a> пэйж хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй хүргэсэн зэрэг олон ажлуудыг дурдаж болохоор байна.</p>	
3.2.2	Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, шалгалтын дүнг тайлагнах;	ТАЕШ -ын хураа мж, бусад	Зохион байгуулсан ТАЕШ-ын тоо - Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн иргэдийн тоо - Зохион байгуулсан тусгай шалгалтын тоо - Нөхөгдсөн сул орон тоо	1, 2, 3, 4 дүгээр улирал - 144 - 17 - 62	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: - 4 - 150 - Сул орон гарсан тухай бүр - Сонгон шалгаруулалт зохион байгуулсан тухай бүр	<p><b>Төрийн албаны ерөнхий шалгалт:</b> Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор баталсан “Төрийн албаны ерөнхий шалгалтын 2025 тов”-ын дагуу Ховд аймагт 1-4 дүгээр улирлын ерөнхий шалгалтыг амжилттай зохион байгуулав.</p> <p>Аймгийн хэмжээнд иргэдийг мэдээллээр хангах зорилгоор <a href="http://www.khovd.gov.mn">www.khovd.gov.mn</a> цахим хуудас, “Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөл”, “Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар” page хуудас болон сум, байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан ерөнхий шалгалтын бүртгэл эхлэх, дуусах, шалгалт авах хугацааны талаарх мэдээллийг нээлттэй, ил тод нийтэлж, олон нийтийн хүртээл болгож ажиллалаа.</p> <p>Тайлант 2025 оны 1-4 дүгээр улирлын төрийн албаны ерөнхий шалгалтад нийт 565 иргэн бүртгүүлснээс 451 иргэн шалгалт өгч ирц 80 хувьтай, ерөнхий мэдлэгийн шалгалтад 201 иргэн буюу 44.6 хувь, монгол хэл бичгийн чадварын шалгалтад 179 иргэн буюу 40.0 хувь, дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад 166 иргэн буюу 37.0 хувь нь нөөцөд бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өссөн дүнтэй байна. Түүнчлэн 2025 оны 1-4 дүгээр улирлын төрийн албаны ерөнхий шалгалтын явцад ямар нэгэн өргөдөл гомдол, санал, сүлжээний, техникийн сааталгүй гараагүй амжилттай зохион байгууллаа.</p> <p><b>Тусгай шалгалт:</b> 2025 онд төрийн захиргааны удирдах албан тушаалын 7 байгууллагаас ирүүлсэн 7 сул орон тоо, гүйцэтгэх албан тушаалын 16 байгууллагаас ирүүлсэн 58 сул орон тоо болон төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 10 байгууллагын 16 албан тушаалын сул орон тооны захиалгыг хүлээн авч нэгтгэн, Төрийн албаны зөвлөлд тусгай шалгалтаар албан тушаалын сул орон тоог нөхөхөөр захиалга хүргүүлж, аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын сул орон тоонд төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн ажиллуулах болон тусгай шалгалтын зар мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу Төрийн албаны зөвлөлийн <a href="https://csc.gov.mn/">https://csc.gov.mn/</a>, аймгийн албан ёсны</p>	100

						<p><a href="https://khovd.gov.mn/">https://khovd.gov.mn/</a> цахим хуудас болон аймгийн Засаг даргын Тамгын газрын <a href="https://www.facebook.com/khovdzdtg">https://www.facebook.com/khovdzdtg</a>, Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн <a href="https://www.facebook.com/">https://www.facebook.com/</a> пэйж хуудсаар тус тус дамжуулан иргэдэд ил тод, нээлттэй зарлаж ажиллалаа.</p> <p>Тайлант хугацаанд төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн ажиллуулах 9 удаагийн зараар төрийн захиргааны удирдах 15, гүйцэтгэх 76, нийт 91 албан тушаал зарласнаас удирдах 4, гүйцэтгэх 8, нийт 12 сул орон тоог зарын дагуу нөхсөн бол төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 3 удаагийн сонгон шалгаруулалтаар 24, төрийн захиргааны удирдах албан тушаалын 5 удаагийн тусгай шалгалтаар 7, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын 4 удаагийн тусгай шалгалтаар 58 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг журмын дагуу зохион байгуулж, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад тэнцсэн 7, төрийн захиргааны удирдах албан тушаалын 7 сул орон тоо тус тус нөхөгдөж, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын 28 сул орон тоонд нэр дэвшүүлснээс 4 иргэн татгалзаж, 24 сул орон тоог нөхсөн дүнтэй байна.</p> <p><b>Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулалт:</b> Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 24 (давхардсан тоогоор) сул орон тоог нөхөх 3 удаагийн тусгай шалгалт (2025.03.14, 2025.09.16, 2025.12.24)-аар Жаргалант сумын 3, Манхан, Мөст, Мөнххайрхан, Цэцэг, Чандмань, Эрдэнэбүрэн сумдын ерөнхий боловсролын сургуулийн захирал, Алтай, Булганы 1, 3, Дуут сумдын цэцэрлэгийн эрхлэгч, Манхан, Чандмань, Үенч сумдын Эрүүл мэндийн төвийн дарга нарын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Манхан, Чандмань, Үенч сумдын Эрүүл мэндийн төвийн дарга, Манхан, Чандмань, Эрдэнэбүрэн сумдын ерөнхий боловсролын сургуулийн захирал, Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч гэсэн 6 сул орон тоог нөхлөө.</p>	
3.2.3	Төрийн албаны зөвлөлийн цахим сургалт, зөвлөлдөх уулзалт, шуурхай хуралдаанд Төрийн	-	Сургалтын тоо - 40 Хамрагдсан албан хаагчдын - 8912	-	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: -	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 10 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар бүрэн хамрагдсан болно.	100

	албаны салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, холбогдох албан хаагчдыг хамруулах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх		тоо		42 - 10000			
3.2.4	Баруун бүсийн төрийн албан хаагчдын зөвлөгөөн зохион байгуулах	5,0 сая	Хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: -	<p>-“Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” баруун бүсийн зөвлөгөөний:</p> <p>- “Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэглээ” хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Хөгжимт драмын театр”-т зохион байгуулж, Ховд аймаг дахь салбар зөвлөлийн дарга, гишүүд, сумдын Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан хаагчдын төлөөлөл 128;</p> <p>- “Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, цахим технологийн хэрэглээ” хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж, Хөдөлмөрийн улсын байцаагч, Нийгмийн ажилтан, Мэдээллийн технологи хариуцсан албан хаагчид, сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтнүүд, төрийн үйлчилгээний удирдах, гүйцэтгэх албан тушаалын албан хаагчдын төлөөлөл 36;</p> <p>- “Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ” хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж, аймгийн нийт Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн төлөөлөл 16;</p> <p>- “Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн карьер хөгжлийг дэмжих, төрийн албан дахь удирдах түвшний жендэр” сургалтад төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын эмэгтэй хаагчдын төлөөлөл 36;</p> <p>- “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” баруун бүсийн зөвлөгөөнд 230, нийт аймгийн 6100 албан хаагчдын төлөөлөл 230 албан хаагч тус тус оролцлоо.</p> <p>Баруун бүсийн зөвлөгөөн нь бүс нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж, шийдлийг хамтдаа эрэлхийлж, зөвлөгөөний үеэр хөндөгдсөн асуудлыг нэгтгэж, хуулийн шинэчлэлд тусгаж ажиллахаараа онцлог болсон төдийгүй Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомж, түүнийг дагаж гарсан журмуудын талаар нэгдсэн ойлголттой болж, төр засгийн бодлого, шийдвэрт</p>		

						тусгуулах тулгамдсан асуудал, төрийн албан хаагчийн үнэт зүйл, ёс зүй, ёс суртахуун, нийгмийн баталгааг хангуулах талаар гаргасан санал, дүгнэлтүүдийг бүсээрээ нэгтгэн дүгнэсэн юм.	
<b>ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>							
<b>4.1. “ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЧАДВАРЛАГ ТӨРИЙН АЛБА” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>							
4.1.1	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн тооцож, ЗДЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-д уламжилна.	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Аймгийн ЗДҮАХ-ийн 2024 оны зорилтуудын хэрэгжилт 91%	Эхний хагас жилд: 50 Жилийн эцэст: Аймгийн ЗДҮАХ-ийн 2025 оны зорилтуудын хэрэгжилт 100	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны жилийн эцсийн биелэлтийг хэлтэс тус бүрээр гаргуулан Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 25-ны 13 дугаар хурлаар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-д уламжлав.	100
4.1.2	Улс, аймгийн аварга малчин, тэргүүний тариаланч, аймгийн есөн алдартан шалгаруулж он цагийн дарааллаар бүртгэл хөтөлж, холбогдох шагналуудыг цаг хугацаанд нь бэлэн болгосон байна.	-	- Шагнагдсан хүний тоо	450	Эхний хагас жилд: 460 Жилийн эцэст: -	2024 онд “Улсын хошой аварга малчин”- 1, “Улсын аварга малчин”-9, “Улсын аварга саальчин”-1, “Улсын аварга тариаланч”-2 шалгарлаа. Мөн 2024 оны ажил үйлсээрээ Аймгийн Аварга малчин, хошой Аварга малчин, Аварга саальчин, Аварга тариаланч-аар тодорхойлогдож ирсэн малчдын тодорхойлолтыг нэгтгэн дүгнэж аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлснээс аймгийн Аварга малчин 73, хошой аварга малчин 12, аварга саальчин 5, аварга тариалан 8 тодорч, он цагийн дарааллаар бүртгэл хөтөлж, холбогдох шагналуудыг цаг хугацаанд нь бэлэн болгон, гардуулан өглөө.	100
4.1.3	Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх ажлыг өргөжүүлэх, хамтын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	-	Төрийн бус байгууллаг аар гүйцэтгүүлсэн ажлын тоо	10	Эхний хагас жилд: 15 Жилийн эцэст: 30	Аймгийн Засаг дарга М.Амарсанаа БНХАУ-ын Шанхай хотноо зохион байгуулсан “Аж үйлдвэрийн паркийн сургалт, хэлэлцүүлэг-2025” арга хэмжээнд оролцож, баруун бүсэд баригдаж буй “Шинэ Ховд” ҮТП-ийн бүтээн байгуулалт, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн талаар танилцуулж, хамтран ажиллах, сайн туршлагаас орон нутагтаа нэвтрүүлэх талаар санал солилцов. БНХАУ-ын Шиньжянь Үжячюй хотноо зохион байгуулсан “Чинху Олон улсын хөрөнгө оруулалтын форум”-д жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуй	70

						нэгжүүдийн хамт оролцож, “Ховд аймгийн Шим Ус ТӨААТҮГ, Шиньжяны Гуо Шин хөдөө аж ахуйн хөгжлийн корпораци”, “Шинэ Ховд Үйлдвэрлэл технологийн парк (Баруун бүс), Үжячюй “Эдийн засаг технологийн хөгжлийн бүс”, “Шинэ Асар ХХК, Шиньжяны Лу Фэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн хөгжлийн компани”, “Монгол улсын Лу Синь гадаадын хөрөнгө оруулалтын компани, Шиньжяны Хэн Жие импорт экспортын худалдааны компани”, “”Пөн Хуй” олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын компани, Шиньжяны “Күнлун” гангийн компани” зэрэг аж ахуй нэгжүүд хооронд хамтран ажиллах гэрээ байгуулав. Бүгд Найрамдах Казахстан Улсын Дорнод Казахстан мужийн Өскемен хотод зохион байгуулсан “Алтай инвест-2025” форумд оролцож, “Шинэ Ховд” ҮТП болон аж ахуй нэгжүүдийн талаар танилцуулж, орон нутагтаа хийхээр төлөвлөж буй төслүүдийн талаар танилцуулав.	
4.1.4	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг <a href="http://www.new.unelgee.gov.mn">www.new.unelgee.gov.mn</a> н Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд шивж, ХШҮ-ний хэлтэст хүргүүлнэ.	-	ЗДЗ-ийн хурлын тэмдэглэлэ эс - Албан бичиг - Тайлангийн тоо	Аймгийн ЗДҮАХ-ийн 2023 оны хэрэгжилтийн тайлан	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Аймгийн ЗДҮАХ-ийн биелэлт тооцож, <a href="http://www.new.unelgee.gov.mn">www.new.unelgee.gov.mn</a> -д шивэх, ХШҮХ-т хүргүүлэх	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг <a href="http://www.new.unelgee.gov.mn">www.new.unelgee.gov.mn</a> Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд шивж, ХШҮ-ний хэлтэст хүргүүлж журмын дагуу архивлан өгсөн. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны зорилтуудын болон аймгийн 2025 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийг <a href="http://www.new.unelgee.gov.mn">www.new.unelgee.gov.mn</a> Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд шивэхээр ажиллаж байна.	100
4.1.5	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах	-	Батлуулсан төлөвлөгөө - сургалтын тоо - Хамрагдсан албан хаагчдын	70 262 100	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 75 300 100	Төрийн албанд ажиллаж байгаа ажилчдаас төрийн албан хаагчийн албан тушаалын онцлог, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээ, эрх зүйн болон төрийн үйлчилгээний стандарт, шаардлагад нийцсэн ажиллах мэдлэг чадвар эзэмшүүлж, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5, Мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад-19, Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-2, Нийт 26 албан	90

	үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулна.		тоо			хаагч Сертификат олгосон. Одоогоор төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад-1, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-5, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад-6, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад-3, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад-1 албан хаагч нийтдээ 16 албан хаагч суралцаж байна. Иймээс тус хөтөлбөрийн хамрах хүрээ хангалттай хэмжээнд явагдаж байна.	
4.1.6	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг ая тухай орчинд ажиллах нөхцөл бололцоог хангана.	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгох - Монгол улсын засгийн газрын тогтоолд заасан сүлжээний дагуу цалин хөлсийг олгох, ажлын үр дүнгээр урамшуулсан. - Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ, ажилласан жил харгалзан зэрэг дэвийн болон удаан жилийн нэмэгдлийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл болон Засаг даргын тамгын газраар шийдвэрлүүлж 4-р улиралд багтаан тайлагнав. - Байгууллагын дотоод журманд заасан сар бүр гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх-12, цалинтай чөлөө-45, мөнгөн урамшуулал-2, буцалтгүй тусламж-14 удаа олгов. 2. Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл боломжоор хангах Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичгийн хэрэгсэл, компьютер зэрэг техник хэрэгслээр нэг бүрчлэн хангагдаж ажиллав. Албан үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай үед унаагаар хангадаг. 3. Орон сууцны нөхцөлөө сайжруулах, орон байраар хангах ахуйн орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг тусалцаа үзүүлэх Орон сууц барих, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авахад зориулж зээл авахад зээлийн баталгаа гаргаж өгч ажиллав Ахмад настнууд болон ажилтнуудад түлээ нүүрсний үнэнд хөнгөлөлт үзүүлж гэр хорооллын айл өрхүүдэд жилдээ 2тн нүүрс/орон сууцны ажилчидад 1 тн нүүрсийг мөнгөн хэлбэрээр олгов Ажилтнуудын өдрийн хоолны үнийн хөнгөлөлтөд өдрийн 5000 төгрөг олгодог болно. 4. Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээнд хамруулах, рашаан сувилал, амралтанд явах дэмжлэг тусалцаа үзүүлэх -Төрийн албан хаагчдыг жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрууллаа. -Аймгийн эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр Улаанбаатар хотод эмчлүүлэх шаардлагатай болсон төрийн албан хаагчид очих унааны зардлын 50 хувийн хөнгөлөлтийг жилд нэг удаа олгож мөн цалинтай чөлөө тухай бүрт нь олгож ажиллав.	100

4.1.7	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	-	Хугацаанд нь хүргүүлсэн тайлан	1	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны тайланг холбогдох хэлтсүүдээс авч нэгтгэн ТЗУХ-ийн даргаар хянуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт нэгдүгээр улиралд багтаан хүргүүлнэ.	100
4.1.8	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу баримт бичиг боловсруулалт, хадгалалт хамгаалалтын горимыг баримталж ажиллахад хяналт тавина.	-	Хүлээн авсан хадгаламжийн нэгжийн тоо - Цахим архивын тоо	100	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, баримт бичгийн стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн, архивын баримтын бүрдүүлэлт ашиглалтын талаар зөвлөгөө өгөн хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлуулан баримтлан ажиллаж байна. Цахим үйлчилгээний нэгдсэн портал <a href="https://erp.e-mongolia.mn">https://erp.e-mongolia.mn</a> системд 17 сум болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд, нийт 149 байгууллага холбогдож, албан хэрэг хөтлөлтийг нийт 1208 төрийн албан хаагч ашигласан байна. Мөн Цахимаар солилцсон албан бичгийн тоо 2025 оны 12 сарын 08-ны байдлаар 1502 ирсэн, 2087 явсан бичгийн цаг хугацаа алдалгүй цахимаар шийдвэрлээд байна.	100
4.1.9	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавина.	-	Хэрэгжилтийн хувь	100	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/70 дугаар захирамжаар Жендэрийн салбар хороог шинэчлэн байгуулж салбар хорооны анхдугаар хуралдааныг 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Хуралдаанаар орон нутгийн салбар хорооны ажиллах чиглэл, 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 4 зорилт бүхий 20 арга хэмжээг хэрэгжүүлж сум бүрд Жендэрийн дэд салбар хороо байгуулж, “Эрэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих” жил болгон зарлах шийдвэр гаргаж эрчүүдийн зөвлөлдөх уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт эрэгтэйчүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, хөвгүүдийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн асуудалд анхаарах, эрэгтэйчүүд, аавуудын нийгэм, гэр бүлийн харилцаан дахь манлайлал, оролцоо нэмэгдсэн.	100
4.1.10	Авлигын эсрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлого хөтөлбөр, авлигын эсрэг төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнана.	-	Тайлан гаргаж, биелэлт хүргүүлсэн байдал	Төлөвлөгөөний хэрэгжилт 2024 онд 85.3 хувьтай хэрэгжсэн.	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Авлигын эсрэг үйл ажиллагааны	АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2025 оны 6 дугаар сард зохион байгуулсан авлигын эсрэг мэдлэг олгох цахим сургалтад аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнүүд, сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, тамгын газрын дарга нар нийт 70 албан хаагчийг хамруулсан. 2. Хэлтсийн ахлах мэргэжилтэн, ЗДТГ-ын ЭБАТ аймгийн төвийн Байгаль орчны газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын газар, Жаргалант сумын ЗДТГ, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Шүүхийн тамгын газар, Хөгжимт драмын театр, Ус цаг уур орчны шинжилгээний төв, Ховд дулааны станц, Мал эмнэлгийн газарт “Авлига ашиг сонирхлын	100

					төлөвлөгөөний биелэлтийг цаг хугацаанд нь АТГ-т тайлагнах	зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Төрийн албан хаагчийн ёс зүй", Авлигын гэмт хэргийн ойлголт сэдвээр танхимын сургалтыг тус бүр байгууллага дээр нь 2025 онд зохион байгуулсан. Нийт 490 албан хаагч хамрагдсан. 3.АТГ-тай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд "Авлигатай тэмцэх газар", "АТГ-Олон нийтийн төв" цахим хуудсуудад тавигдаж байгаа шторк, богино хэмжээний кино, постеруудыг аймгийн албан ёсны сайт Khovd.gov.mn, Khovd.khural.mn, khovdnews.mn, newkhovd.mn болон аймгийн ЗДТГ-ын цахим хуудас, "Ховд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл", орон нутгийн Ховд телевиз, Олон ястны телевизүүдээр мөн "Эрх зүйн мэдээлэл сурталчилгаа" цахим хуудас зэрэг сошиаль сувгуудаар олон удаагийн давтамжтайгаар нийтэд хүргэж сурталчилсан. 4. Төрийн албаны хүнд суртал, авлигаас урьдчилан сэргийлэх, E-Mongolia-с авах төрийн үйлчилгээг сурталчилсан 1 видео контентыг хийсэн.	
4.1.11	Үндэсний байдлыг төлөвлөгөө хэрэгжилтийг ажиллах аюулгүй хангах гаргаж, хангаж	-	Тайлангийн биелэлт /хувь/	Тайлан 2024 онд 96,5 хувьтай хэрэгжсэн	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тайланд тусгагдсан үйл ажиллагааг 95-с доошгүй хувиар хэрэгжүүлнэ.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 163 дугаар тогтоолоор Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах байнгын ажлыг хэсгийг аймгийн удирдлагууд, тусгай чиг үүргийн болон эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудын бүрэлдэхүүнтэй байгуулж үйл ажиллагаа тогтмол явуулж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар тус ажлыг хариуцсан албан тушаалтныг 2019 оноос хойш томилон ажиллуулж байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2025 оны 10 дугаар сард зохион байгуулсан "Сөргө-2025" команд штабын сургалтыг орон нутагт амжилттай зохион байгуулж ажлын хэсгийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр хамрууллаа. Мөн Ховд аймгийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг шинээр боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ховд аймагт Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 10 зорилт, 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 2025 оны эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 89,1 хувьтай үнэлэгдсэн. Мөн Ховд аймагт үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагын танилцуулах мэдээ, хатуу болон аюултай хог хаягдал түүний менежментийн мэдээлэл, Ховд аймгийн гадаад улсын элчин сайд болон бусад төлөөлөгчидтэй хийсэн уулзалт, ярианы тэмдэглэл, байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн талаарх товч бүртгэлийн мэдээлэл зэргийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд хугацаанд нь хүргүүлж тайлагнасан.	90
4.1.12	Аймгийн ЗДТГ-ын	-	Хугацаанд	12	Эхний	Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн	100

	сарын ажлын мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.		нь тайлагнасан сарын мэдээний тоо		хагас жилд: - Жилийн эцэст: 12	чиглэлийн дагуу 2025 оны 10 дугаар сараас эхлэн сарын мэдээг засаглал, нийгмийн хөгжлийн, хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн, байгаль орчин, ногоон хөгжлийн, хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөв санхүүгийн бодлого, дэд бүтэц бүтээн байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх гэсэн 6 чиглэлээр ангилан тулгамдсан болон хоцорч буй ажил, үр дүнд хүрсэн ажил гэсэн төрлөөр бэлтгэж new.unelgee.gov.mn системд шивж сар бүрийн 5-ны дотор оруулж байна.	
4.1.13	Аймгийн 2024 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	-	Батлуулсан төлөвлөгөө - Хэрэгжилтийн хувь	100	Эхний хагас жилд: 50 Жилийн эцэст: 100	Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/11 захирамжаар аймгийн 2025 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний саналыг сум, байгууллагуудаас авч, нэгтгэн батлуулсан. Нэгдсэн арга хэмжээнд туссан арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж байна.	100
4.1.14	Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлыг зохион байгуулж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	-	Зөвлөлийн хурлын тэмдэглэлийн тоо - Тэмдэглэл эс тоо - Хэрэгжилтийн хувь	11 25 100%	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухайн үед хуралдсан тоо Тухайн үед гаргасан тэмдэглэлээс 100	Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/60 дугаар захирамжаар баталсан “Зөвлөлийн бүрэлдэхүүн, хурлын журмыг шинэчлэн батлах тухай” захирамжийн дагуу Зөвлөлийн хурлыг хуралдуулах бэлтгэл ханган ажиллалаа. Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Зөвлөлийн 13 удаагийн хурал зарлаж, тус хуралдаануудаар хэлэлцүүлэх асуудлыг холбогдох албан тушаалтнуудаас “Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлын журам”-ын 2.4-д заасны дагуу хүлээн авч viber группээр дамжуулан Зөвлөлийн гишүүдэд хүргүүлж, хуралдаан зохион байгуулах бэлтгэлийг ханган ажиллалаа. Мөн зөвлөлийн хурлын бэлтгэл ханган нөтбүүк бэлдэн сүлжээнд холбож, шаардлагатай тохиолдолд хурлын материалуудыг олшруулан бэлтгэл ханган ажилласан.	100
4.1.15	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх	-	Сахилга, ёс зүйн зөрчил гарсан албан хаагчийн тоо	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 0	Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтын Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмаар Хяналт-шинжилгээ үнэлгээний цахим санд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллаж байна. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ Төрийн албаны хууль, холбогдох журмын дагуу төрийн албан хаагчдын харилцаа хандлага, багаар ажиллах чадварыг байгууллагын албан хаагчдаар үнэлүүлэхийн зэрэгцээ	100

	хариуцлагыг чангатгана.					гүйцэтгэлийг үнэлэхэд иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг тооцдог болов.	
4.1.16	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг хянан баталгаажуулна.	-	Хянасан гэрээний тоо - Гэрээний үнэлгээ (хувиар)	26 90%	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 26 91%	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 25 агентлаг, Номын сан, Музей, ХДТ, Ойн ангийн 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг Хяналт шинжилгээний үнэлгээний хэлтсээр үнэлгээ хийлгүүлж, Засаг даргаар баталгаажуулав. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 25 агентлаг, Нийтийн номын сан, Музей, Хөгжимт драмын театр зэрэг нийт 28 байгууллагын дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулах арга хэмжээг 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Нутгийн удирдлагын ордны хуралдааны их танхимд зохион байгууллаа.	100
4.1.17	Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай “Төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ” байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн дүгнүүлнэ.	-	Байгуулсан гэрээ - Гэрээний үнэлгээ (хувиар)	17 85%	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 17 90%	Иргэний хуулийн 195-205 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19-22 дугаар зүйл, 27 дугаар зүйлийн 27.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, 39.3 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн сум, орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр дүнг санхүүжүүлэх зарчмыг удирдлага болгон “Төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ”-г сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулах арга хэмжээг 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Нутгийн удирдлагын ордны хуралдааны их танхимд зохион байгууллаа. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон сумдын Засаг дарга нарын 2025 оны гэрээний хэрэгжилт, үр дүнг 12 дугаар сарын 15-ний дотор хүлээн авч тайланг нэгтгэн дүгнэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	100
4.1.18	Аймгийн Засаг даргаас Ерөнхий сайдын Батламжийн биелэлт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Шадар сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг тус тус тооцож, тайлагнана.	-	Хугацаанд нь хүргүүлсэн тайлан - Хэрэгжилтийн хувь	3 91%	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 3 92%	Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг Ховд аймагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний чиг үүргийн дагуу аймгийн Онцгой байдлын газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Худалдан авах ажиллагааны газар холбогдох байгууллагуудаас гэрээний заалтын дагуу биелэлтийг нэгтгэн Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс рүү хянуулахаар хүргүүлэв. Засгийн газрын тогтоол- 40 заалт-100 хувийн хэрэгжилттэй, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-37 заалт-100 хувийн хэрэгжилттэй, Ерөнхий сайдын захирамж-3 заалт 100 хувийн хэрэгжилттэй, Засгийн газрын албан даалгавар-32 100 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст цаг хугацаанд хүргүүлээ.	100
4.1.19	Аймгийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд,	-	Хэрэгжилтийн хувь	20	Эхний хагас	Аймгийн Засаг дарга, Засгийн газрын гишүүд сайд нартай байгуулсан 2025 онд хамтран ажиллах гэрээг холбогдох	100

	сайд нартай байгуулсан гэрээний биелэлтийг тайлагнахад хяналт тавина.				жилд: - Жилийн эцэст: 20	мэргэжилтнүүдэд нь нэгдүгээр сард хүлээлгэн өгч хяналтад авхуулсан. Хагас жил, жилийн эцсийн байдлаар гэрээний биелэлтийг тооцон хүргүүлэх хугацааны цаглабарыг гаргаж, хариуцсан мэргэжилтнүүдэд нь танилцуулж, биелэлт үр дүнг хугацаанд нь хүргүүлэхэд хяналт тавин ажиллаж байна.	
4.1.20	“Эхийн алдар одон”-гийн материал хүлээн авч, журмын дагуу бүрдүүлж, ЕТГ-т хүргүүлнэ.	-	Хугацаанд нь хүргүүлсэн материалын тоо	Тухайн үед ирүүлсэн материал	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухайн үед ирүүлсэн материал	Сумдаас Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн хүрээнд "Эхийн алдар" 1, 2 дугаар зэргийн одонгоор шагнагдах эхчүүдийн материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 13 дугаар зарлигаар батлагдсан "Эхийн алдар" одонгоор шагнах журмын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 01-ний дотор хүлээн авч материалыг журмын дагуу нэг бүрчлэн хянан, хадгаламжийн нэгж бүрдүүлж аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, Засаг даргын 2025 оны А/299 дугаар захирамжийн хамт Ерөнхийлөгчийн Тамгын газарт албан бичгээр хугацаанд нь хүргүүлэн ажиллав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 58 дугаар зарлигаар “Алдарт эх” I, II зэргийн одонгоор шагнагдсан эхчүүдийн одонг ёслол төгөлдөр гардуулах ажлыг зохион байгуулан гардуулан өгөв. Ховд аймгийн хэмжээнд 496 ээж “Алдарт эх”- одон авч, үүнээс 103 ээж нэгдүгээр зэргийн одон, 394 ээж хоёрдугаар зэргийн одон хүртлээ. Мөн шинэчлэн батлагдсан журмын дагуу 150 ээж одонгоо нөхөн авсан.	100
4.1.21	Төрийн дээд одон медалиар шагнуулахаар тодорхойлсон иргэдийн холбогдох материалыг хүлээн авч, журмын дагуу шийдвэрлэнэ.	-	Хугацаанд нь хүргүүлсэн материал	Тухайн үед ирүүлсэн материал	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухайн үед ирүүлсэн материал	2025 онд аймаг, орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан, боловсрол, эрүүл мэнд, барилга, авто тээвэр, банк санхүү, нийтийн аж ахуй үйлчилгээ, хөдөө аж ахуй зэрэг салбаруудын төр, хувийн хэвшлийн байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан ахмад настнууд болон ажиллаж байгаа иргэдийг төрийн дээд одон, медальд тодорхойлсон материалыг журмын дагуу бүрдүүлж Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжлан ажилласан.	100
4.1.22	Аймгийн шагналаар шагнуулахаар тодорхойлсон иргэдийн холбогдох материалыг хүлээн авч, журмын дагуу шийдвэрлэнэ.	-	Хугацаанд нь хүргүүлсэн материал	Тухайн үед ирүүлсэн материал	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухайн үед ирүүлсэн материал	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.2, 3.3.3 дахь заалтуудыг үндэслэн Улс, аймгийн нийгэм эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалтын үйлсэд үр бүтээлтэй ажиллаж өндөр амжилт гаргасан иргэдийг шагнаж урамшуулж алдаршуулах журмын дагуу аймгийн Зуун эрхэм-9, аймгийн Хүндэт иргэн-11, Жуух бичиг-286, Хүндэт Өргөмжлөл-152, аймгийн Хүндэт тэмдэг-160, Ховдын төлөө-111-р нийт 730 иргэнийг шагнасан байна.	100

					материал		
4.1.23	Аймгийн Засаг даргын нөөцөөс хөрөнгө гаргах тухай Засаг даргын захирамж, үнэлгээний хороо байгуулах тухай ЗДТГ-ын даргын тушаал гаргана.	500.0	Захирамж, Тушаалын тоо	Захирамж -32 тушаал-138	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тухай бүр	Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам-ын дагуу аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 54 захирамж төлөвлөн батлуулсан. Тус захирамж төлөвлөхтэй холбогдуулан зохион байгуулж буй болон төлөвлөсөн арга хэмжээний тайлангууд болон санхүүгийн баримтыг бүрдүүлэн ажиллаж байна.	100
4.1.24	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний болон салбар, орон нутгийн бодлого, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх салбар дундын бодлого зохицуулалтыг хангаж, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.	-	Боловсруулсан төлөвлөгөөний тоо - Арга зүйн дэмжлэг үзүүлсэн тоо	15	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 15	Аймгийн хэмжээнд “Харилцан хүндэтгэе”, “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх алхамт аян” зэрэг 2 аяныг өрнүүлж хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлэе уриан дор аймаг сумдын Засаг даргын тамгын газар, Засаг даргын эрхлэх хүрээний 25 агентлаг, Аймгийн Жендэрийн салбар хороо, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд, Ховд аймагт үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагууд, 18,000 орчим хүүхэд, 2000 гаруй насанд хүрэгчид хамрагдаж 12 төрлийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа. Тус 2 аянтай холбоотой 18 удаагийн мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэсэн ба нийт мэдээллийн 35% нь телевизээр, 65% нь сайтаар хүргэгдсэнээр хуулийн хэрэгжилт сайжирч байна.	100
4.1.26	Жендэрийн боловсролыг бүх нийтэд түгээх, орон нутгийн түвшинд хамтын ажиллагааг өргөжүүлэх, холбогдох тайлан, мэдээ, мэдээллийг боловсруулах, нэгтгэх, тайлагнах	-	Зохион байгуулсан сургалтын тоо - Тайлан, мэдээний тоо	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 15	Жендэрийн Үндэсний хорооноос НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд жендэрийн өөрчлөлтийн арга зүйг нэвтрүүлэх, жендэрийн дүн шинжилгээнд суурилсан хариуцлагатай бодлого, төлөвлөлт, төсөвлөлт боловсруулах менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Жендэрийн Үндэсний сургагч багш Я.Төгөлдөр аймгийн удирдлагуудтай уулзаж, хөтөлбөрийн зорилго, зорилтыг танилцуулахын зэрэгцээ Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг хангах, Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого, Жендэрийн хариуцлагатай төлөвлөлт, төсөвлөлт “Жендэрийн өөрчлөлтийн арга зүйг бодлого, төлөвлөлтөд ашиглах” талаар сургалтад 100 гаруй хүн хамрагдсанаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, дараагийн шатны холбогдох бодлого, төлөвлөгөөнд тусгасан.	100

4.1.26	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийг хууль журамд нийцүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнана.	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байдал	Хуулийн хугацаанд албан тушаалтнууд хөрөнгө орлогоо гаргаж тайлагнадаг.	Эхний хагас жилд: - Жилийн ХАСУМ болон ХАСХО М-ийг мэдүүлэг гаргагчдаар гаргуулан хянаж хугацаанд нь тайлагнасан байна. Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Тайлант хугацаанд буюу 2024 оны ХАСХОМ гаргах 207 албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд 100 хувь гаргуулж цахим системд шивж баталгаажууллаа. ХАСХОМ-1, ХОМ хураангуй, ХАСХОМ-3, ХАСХОМ-4, ХАС хураангуй тайлангуудыг журамд заагдсан хугацаа болох 3 дугаар сарын 1-ний дотор албан бичгээр, мөн тайлангуудыг Sargulzaya@iaac.mn цахим хаягаар тус тус Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлсэн. 2025 онд шинээр албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 145 албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж хянуулсан. Мэдүүлгийн тайлан мэдээг үнэн зөв, хуулийн хугацаанд, маягтын дагуу, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэлийг бүрэн хөтөлсөн. Мөн цахим программын ЭБАТ цэсний ХАСУМ-ийн бүртгэлийг давхар хөтөлж мэдээллийг оруулсан. ХАСХОМ болон ХАСУМ, ашиг сонирхлын зөрчлийн асуудал, мэдэгдэл, тайлбар гаргах чиглэлээр 5 удаагийн цахим болон танхимын сургалтыг сум, байгууллагын албан хаагчдад зохион байгуулж нийт 180 хүнийг хамруулсан.	100
4.1.27	Архивын баримтыг цахимжуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, биелэлтийг тайлагнана.	-	Цахимжуулсан баримтын тоо	2024 онд 2 хөмрөгийн дансны 47 ширхэг хадгаламжийн нэгж буюу 2001 хуудсыг цахимжуу	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 2025 онд 2 хөмрөгийн дансны 137 хадгаламжийн нэгжийг	Архивын өрөө тасалгааг сайжруулах, архивын нэгжийн хадгалах хамгаалах орчин нөхцлийг сайжруулах журмаар 2025 оны 09 дүгээр сард "Төгс шимт оргил" ххк тай гэрээ байгуулан архивын нягтруулсан шүүгээ 15 ширхэг, Галын самбар 2ш, усны хувин 4ш, элсний хувин 4 ширхэгийг аван зориулалтын өрөөнд байрлуулан ашиглаж эхлэв. 2025 онд 2024 оны хөтлөгдөж дуусаад архивд шилжүүлэн өгсөн байнга хадгалах хадгаламжийн нэгж 70, түр хадгалах хадгаламжийн нэгж 147, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж 12-ыг хүлээн авч, 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл Засаг дагын А захирамж 946, Б захирамж 62, Засаг дагын Тамгын газрын даргын А тушаал 127, Б тушаал 227-г khovd.gov.mn цахимд оруулан ажиллаж байна. Мөн архивын нэгжийг цахимжуулах	100

				лсан.	цахимж уулна.	зорилгоор зөөврийн хард нэгийг авч 2010 оноос 2019 он хүртлэх ЗД захирамж, ТГ-ын даргын тушаалыг цахимжуулан хадгалаад байна.	
4.1.28	Архивын баримтаар нөхөн бүрдүүлэлт хийх ажлыг гүйцэтгэнэ.	-	Нөхөн бүрдүүлсэн баримтын тоо	2024 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 4 барилга байгууламжийн 126 ширхэг баримт бичгээр нөхөн бүрдүүлэлт хийсэн.	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 2025 онд төрийн болон төсөвт байгуулагча, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэлээр 2000-2017 оны 1500 ширхэг баримтаар нөхөн бүрдүүлэлт хийнэ	Ногоон байгууламж бүхий тохижилтын багц ажлуудын хүрээнд Ховд, Мянгад, Буянт, Чандмань сумдын тохижилтын ажил, аймгийн нийтийн эзэмшлийн орон сууцны халаалтын шугам солих 7 багц ажил, нийтийн эзэмшлийн замын 5 багц ажил, аймгийн төвийн 0,4 кв шинэчлэлийн 2 багц ажил, Малчны хорооллын дээд чиглэл, Туулайт чиглэлийн тус бүр 1 багц ажил, Шинэ дулааны өргөтгөл шинэчлэлт 1 багц, Цэцэг сумын Эрүүл мэндийн төв барилгын ажлыг хүлээн улсын комиссын бүрэлдэхүүнд улсын байцаагч ажиллан, холбогдох баримт бичгээр хадгаламжийн нэгжийн бүрдүүлэлт хийж байна.	100
4.1.29	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд	-	Хууль тогтоомж, тогтоол	Хууль тогтоомж, тогтоол	Эхний хагас жилд: -	Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны эхний хагас жилийн 163 шийдвэрийн 270 зүйл заалтын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 88,0 хувьтай үнэлж, 2025 оны 07	100

	мониторинг хийж, үр дүнг тооцох, тайлагнах		шийдвэрийн хэрэгжилтэд мониторинг хийсэн тайлан, Удирдлагын багийн хурлын тэмдэглэл, албан бичиг	шийдвэрүүдийн хэрэгжилтийн 2024 оны тайлан	Жилийн эцэст: ХТТШ-ийн биелэлтэд мониторинг хийж, аймгийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ЗГХХГ-ын www.new.unelgee.gov.mn сайтад шивж оруулан баталгаажуулж, ЗГХХГ-т хүргүүлсэн байна	дугаар сарын 08-ны өдрийн 1/1589 дүгээр албан тоотор ЗГХХГ-т хүргүүлж, ЗГХХГ-ын цахим систем www.new.unelgee.gov.mn сайтад шивж оруулан баталгаажууллаа. Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг улирал бүр аймгийн www.khovd.igovernment.mn ХШҮМЦС-ээр хэлтэс, сум, байгууллагуудаас гаргуулан авч тооцон, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХХГ-ын www.new.unelgee.gov.mn сайтад оруулан баталгаажуулж байгаа бөгөөд нийт 9 удаа тооцож, заасан хугацаанд нь ХШҮ хийж, баталгаажуулсан болно. 2025 оны жилийн эцсийн биелэлтийг тогтоосон хугацаанд нь тооцож ХШҮ хийхээр ажиллаж байна.	
4.1.30	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд мониторинг хийж, үр дүнг тооцох, тайлагнах	-	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд мониторинг хийсэн тайлан, Удирдлагын багийн	Бодлогын баримт бичгийн 2024 оны хэрэгжилтийн тайлан	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Бодлогын баримт бичгийн биелэлт	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд тухай бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХХГ-ын цахим сайт new.unelgee.gov.mn сайтад шивж оруулан баталгаажуулж, үр нөлөөг сайжруулах санал, зөвлөмж боловсруулан, холбогдох сум, байгууллага, хэлтсүүдэд хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллалаа. 2025 оны тайлант хугацаанд "Алсын хараа-2050" урт хугацааны БББ-т 1 удаа, Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 9 удаа, ЭЗНҮ-ийн биелэлтэд 1 удаа, ЗДҮАХ-ийн биелэлтэд 1 удаа, аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд 2 удаа, дэд хөтөлбөрүүдийн	100

			хурлын тэмдэглэл, албан бичиг		эд монито ринг хийж, аймгийн Удирдл агын багийн хурлаар хэлэлцү үлэн, ЗГХХГ-ын www.new.unelg ee.gov.mn сайтад шивж оруулан баталга ажуулж, ЗГХХГ-т хүргүүл сэн байна.	биелэлтэд 1 удаа, аймгийн 5 жилийн үндсэн чиглэлийн биелэлтэд 1 удаа, хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтэд 1 удаа, сайдуудын гэрээний биелэлтэд 1 удаа, аймгийн шилэн дансны хөтлөлтөд 1 удаа, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр болон сургалтын хөтөлбөрт 1 удаа, ил тод байдлыг хангах үзүүлэлтэд 1 удаа, Ерөнхий сайдын албан даалгаврын биелэлтэд 3 удаа, дээд газраас өгөгдсөн үүрэг даалгавар, мөн Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгавар өгсөн тухай бүрт, ЗГХХГ-аас биелэлт тооцож ирүүлэхээр өгсөн үүрэг даалгавар бүрийн биелэлтийг тооцож хугацаанд нь хүргүүлсэн бөгөөд, захиргааны байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө, орон нутагт мөрдөж буй захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн явцад болон орон нутгийн ХШҮМЦС <a href="http://khovd.igovernment.mn/">http://khovd.igovernment.mn/</a> -д оруулсан удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгавруудын хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ хийж, холбогдох тайлан, зөвлөмжүүдийг хүргэн ажилласан байна.	
4.1.31	Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах аргачлалыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийн үр дүнг тайлагнах	-	Шинэчилсэн журам болон аймгийн хэмжээнд ХШҮ-ний <a href="http://khovd.igovernment.mn/">http://khovd.igovernment.mn/</a> , <a href="https://plan.igovernment.mn/">https://plan.igovernment.mn/</a> цахим сис-тем нэвтэрсэнтэй уялдаж боловсруу-	Аймгийн Засаг даргын 2021 оны А/808 дугаар захирамжаар баталсан аргачлал	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Аргачлал батлагдан хэрэгжиж, аргачлалын дагуу сум, байгуул	"Аргачлал шинэчлэн батлах" тухай аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 17 –ны өдрийн А/808 дугаартай захирамжаар "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ыг батлуулсан бөгөөд, сум, байгууллагуудад зөвлөн туслах чиглэлээр болон, жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх зорилгоор хийж буй хяналт-шинжилгээ үнэлгээнд тус аргачлалыг удирдлага болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд ХТТШ-ийн биелэлтийг 9 удаа, ЗГҮАХ-ийн биелэлтийг 1 удаа аймгийн <a href="http://khovd.igovernment.mn/">http://khovd.igovernment.mn/</a> ХШҮМЦС-ээр дамжуулан авч, биелэлт тооцсон байна. ЗДЭАХ-ийн 27 байгууллагын гүйцэтгэлийн тайланд болон аймгийн ЗДТГ-ын хэлтэс, нэгжүүдийн 2024 оны гүйцэтгэлийн тайланд хяналт, шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтанд хүргүүлээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний журам нь Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдаж, мөрдөн ажиллаж байгаа бөгөөд үүний дагуу аймагт	70

			лан батлуулсан аргачлал, түүний дагуу сум, байгууллагуудад хяналт хийсэн тоо, зөвлөмж, тайлан		лагуудаас ирүүлсэн хөтөлбөр, эрх зүйн актуудын хэрэгжилтийн тайланд хяналт шалгалт хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.	хэрэгжүүлэх журмыг шинэчлэн батлуулахаар төслөө боловсруулсан боловч, тус 43 дугаар журамд дахин өөрчлөлт хийх болсонтой уялдан аймагт хэрэгжүүлэх журмыг батлуулах асуудлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан болно.	
4.1.32	Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан боловсруулах, үр дүнг тооцох, тайлагнах	-	Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	Аймгийн ЗДТГ-ын 2023 оны Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Аймгийн ЗДТГ-ын 2023 оны Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.1.2-д заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг бичиж, Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны үнэлгээний дүнг нэгтгэн гаргав. Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны үнэлгээний дүн 2024 оны жилийн эцсийн байдлаар 89,0 хувийн хэрэгжилттэй дүгнэгдлээ. Журмын дагуу 11 бүлэг тайлангийн үнэлгээг тус бүрд нь товчоолон, дүгнэлт хийж, хавсралтаар гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв. Үүнд: 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 95,03 хувь; 2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 90,5 хувь, 3. Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 85,0 хувь; 4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 91,01 хувь; 5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ 94,3 хувь; 6. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 91,06 хувь; 7. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт 88,7 хувь; 8. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ 97,7 хувь; 9. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ 72,9 хувь, 10. Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг даргатай	100

						байгуулсан гэрээний үүргийн биелэлт 90,3, 11. Засгийн газрын Тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээ (3 үзүүлэлтээр) 82,2 хувьтай тус тус хэрэгжсэн байна. 2025 оны ХШҮ-ний тайлан дараа оны 03 дугаар сарын 1-ний дотор гарах болно.	
4.1.33	Орон нутагт бодлогын үнэлгээний тогтолцоог нэвтрүүлж, бодлогын үр дүнг хэмжих, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төрийн хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, ил тод байдлыг хангах	-	Бодлогын үнэлгээний нэгдсэн төлөвлөгөөнд тусгах санал, үнэлгээ хийх бодлогын тоо	-	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Үнэлгээний тайлан, зөвлөмж, үнэлгээ хийх төлөвлөгөөний биелэлт	Хугацаа болоогүй бөгөөд журмын дагуу дараа оны 03 дугаар сарын 01-ний дотор ЗГХХГ-г хүргүүлэх болно.	ХБ
4.1.34	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, сумдын ЗДТГ, баг, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд мониторинг хийж, мэргэшил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч, сургалт зохион байгуулах, үр дүнг аймгийн Удирдлагын багт танилцуулах	-	Сум, баг, байгууллага удад явцын болон үр дүнгийн хяналт шалгалт, мониторинг хийсэн тоо, өгсөн зөвлөмж, сургалтын тоо	17 сум, баг, төсөвт байгууллагууд, ЗДЭАХ-ний агентлагийн үйл ажиллагаанд мониторинг хийсэн тайлан, хүргүүлсэн зөвлөмж, зохион байгуулсан сургалт	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Удирдагчийн дагуу, мониторинг хийж, сум, баг, байгууллагуудын үйл ажиллагааг дүгнэх, үр дүнгээр нь	ЗДЭАХ-ний 27 байгууллагын гүйцэтгэлийн тайланд болон аймгийн ЗДТГ-ын хэлтэс, нэгжүүдийн 2024 оны гүйцэтгэлийн тайланд хяналт, шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн бөгөөд байгууллага, хэлтэс тус бүрт санал, зөвлөмж хүргүүллээ. Сум, баг, байгууллагуудын 2025 оны жилийн эцсийн үр дүнгийн хяналт шалгалтыг дараа оны 1 дүгээр сард хийхээр төлөвлөн ажиллаж байна.	90

					зөвлөмж боловсруулан хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт-шалгалт, мониторинг, сургалт хийж, үрдүнг танилцуулах, Удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулсан байна	
<b>4.2. “ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:</b>						
4.2.1	УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрт дэд бүтцийн хамааралтай	УТ, ОНТ	хэрэгжилтийн хувь	90	Эхний хагас жилд: -	Сар бүр УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрийн нийгмийн салбарын хамааралтай зорилтуудыг хяналтандаа авч, хэрэгжилтийг хангуулж, төрийн мэдээллийн сүлжээгээр
						100

	зорилтуудын хэрэгжилтийг хангуулж, тайлагнах.				Жилийн эцэст: 100	хугацаандаа тайлагнаж ажиллалаа.	
4.2.2	Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт дэд бүтцийн чиглэлээр тусгагдсан заалтуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж, дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах.	УТ, ОНТ	хэрэгжилтийн хувь	85	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хяналтад авч орон нутагт хэрэгжилтийг хангалаа.	100
4.2.3	Монгол улсын болон аймгийн эдийн Засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд дэд бүтцийн талаар тусгагдсан зорилт, заалтын хэрэгжилтийг хангуулж, гүйцэтгэлийг тооцож, тайлагнах.	УТ, ОНТ	хэрэгжилтийн хувь	85	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Аймгийн 2025 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгэм эдийн засгийн дэвшүүлсэн бодлого, зорилтыг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас баталсан “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн хэрэгжилтийг Төсвийн бүх шатны байгууллага, төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлын эсрэг хязгаарлалт тогтоох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулан ажиллахыг төсвийн Ерөнхийлэн захирагчаас үүрэг чиглэл өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаа.	100
4.2.4	Эрчим хүчний сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжүүлэн ажиллах	УТ, ОНТ	хэрэгжилтийн хувь	99	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Сайдтай байгуулсан гэрээний жилийн эцсийн биелэлтийг тооцон хяналт-шинжилгээ үнэлгээ хийлгэж 12.25-ны дотор Эрчим хүчний яаманд хүргүүлсэн.	95
4.2.5	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр баталсан нийт төсөл арга хэмжээний ажлын даалгавар хянаж тендер зарлуулах	УТ, ОНТ	Хяналт хийсэн төсөл арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 106	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар баталсан нийт 108 төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгаварыг боловсруулан худалдан авах ажиллагаа зарлуулсан.	100
4.2.6	Тендер шалгарсан төсөл арга хэмжээний гэрээ хийж, зураг төсөв,	УТ, ОНТ	Төсөл арга хэмжээний	0	Эхний хагас жилд: -	Худалдан авах ажиллагаанаас шалгарсан гүйцэтгэгчтэй ХЭЗХ-ээс гэрээ байгуулсан төсөл арга хэмжээний зураг төсөв, ажлын тоо	90

	ажлын даалгаврын дагуу хяналт хийж ажиллах.		тоо		Жилийн эцэст: 100	хэмжээнд захиалагчийн хяналт тавин ажилласан.	
4.2.7	Гэрээ хийсэн төсөл арга хэмжээнд хяналт хийж, ажил хүлээн авах улсын Комисст ажиллах, гэрээний үүргийн биелэлт тооцох	УТ, ОНТ	Төсөл арга хэмжээний тоо	250	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 106	Гэрээт ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавьж, улсын комисст ажилласан ба гэрээг дүгнэж санхүүжүүлсэн.	100
4.2.8	Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээнд тусгагдсан дэд бүтцийн төслийг хурдтай хөгжлийн зам үйл ажиллагаанд уялдуулан хэрэгжүүлэн ажиллана.	УТ, ОНТ	Гэрээ хийсэн төсөл арга хэмжээний тоо	0	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтад тусгагдсан "Хурдтай хөгжлийн зам" хөтөлбөртэй уялдсан дэд бүтцийн чиглэлийн 12 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ашиглалтад хүлээн авсан.	100
4.2.9	Ховд голын Шижигтийн хавцалд Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станцын барилга угсралтын ажилд хяналт тавьж ажиллах	УТ, ОНТ	хэрэгжилтийн хувь	30	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Эрдэнэбүрэнгийн УЦС-ын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхэд орон нутгийн зүгээс шаардлагатай асуудлыг тухай бүр шийдвэрлэж, хамтран ажиллаж байна. Энэ онд орон нутгийн төсвөөс санхүүжилт гараагүй.	50
4.2.10	"Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/-н барилга угсралтын ажлыг эхлүүлэх	УТ ОНТ	Ажлын гүйцэтгэлийн хувь	60	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Үйлдвэрлэл технологийн паркийн хөрөнгө оруулалтанд орон нутгийн "Шинэ Ховд" баруун бүсийн хөгжлийн корпораци Орон нутгийн өмчийн оролцоотой ХХК-нд хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж, үйл ажиллагааны зардалд 350,0 сая төгрөгийгн санхүүжилтийг олгож, гүйцэтгэлээр санхүүжилтээ авсан.	70
4.2.11	Төр, хувийн хэвшлийн түншлэл, харилцааг өргөжүүлэн, ААН-үүдийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.	ҮАЗ	Борлуулалтын орлого, ашиг алдагдал	Бор-510.0 тб Ашиг-16.0 тб	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Бор-535.5 тб Ашиг-	Төр, хувийн хэвшлийн түншлэл, харилцааг өргөжүүлэн, ААН-үүдийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Нийт 16 сумын төсвийн байгууллагуудын байрны халаалтыг 2025 онд аж ахуйн нэгжүүдтэй гэрээлэн гүйцэтгүүлж төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэн бизнесийн үйл ажиллагааг дэмжиж байна. 1. "Жаргалант ТҮК" ОНӨААТҮГ- тай гэрээ байгуулан Ховд хотын нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, хог хаягдлыг цэвэрлэх, ачиж зайлуулах ажлыг гүйцэтгүүлэн зардалд	90

					16.8 тб	1094,6 сая төгрөгийг төлөвлөн сарын хуваарийн дагуу санхүүжүүлж байна. 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж сар бүр санхүүжилтийг хуваарийн дагуу олгож байна. 3. Засгийн газрын 2024 оны 86 дугаар "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын хүрээнд "Теле камерын хяналтын дэд төв"-ийг байгуулан үйл ажиллагааны зардалд 238,0 сая төгрөгийг гүйцэтгэлээр санхүүжүүлж байна. 6. Шинэ Ховд ББХК ОНӨОХХК-ний үйл ажиллагааны санхүүжилтэнд 350,0 сая төгрөгийг тусган санхүүжүүлсэн. Мөн сумдын ИТХ-ын төсөвт 161,6 сая төгрөг, ЗДТГ-ын төсөвт 170,8 сая төгрөгийг тусган хувийн хэвшлийг дэмжих зорилгоор хуваарилан санхүүжүүлж байна. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар аймгийн нийт борлуулалт урьд оныхоос өссөн. Мөн ашиг урьд оныхоос өссөн үзүүлэлттэй гарсан.Жилийн эцсийн тайлан авахдаа хуулийн дагуу аудитын байгууллагаар баталгаажуулах шаардлагатай 118 тайланг 26 аудитын компаниудаар баталгаажуулж нэгтгэлд авсан. 2025 оны 2-р улиралд 249 ААНБ-ын тайланг баталгаажуулсан. Нийт давхардсан тоогоор 2324 ААНБ-ын тайланд баталгаажилт хийсэн байна.	
4.2.12	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг зөвшөөрлийн цахим системээр бүртгүүлэх, бүртгэгдсэний дараа зөвшөөрөл олгоно.	-	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн тоо	5	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 5	Санхүүгийн Зохицуулах хорооны даргын 2025 оны 04-р сарын 25-ны Б/110 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэгтэй хамтарч 5-р сарын 8-9 өдрүүдэд зохион байгуулсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болон Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлын хүрээнд Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид болон мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх, холбогдох хууль журмын талаар мэдлэг олгох танхимын сургалтанд хамаарал бүхий 39 хүн хамрагдлаа. Эхний жилийн эцсийн байдлаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр 1 аж ахуйн нэгж, иргэнээр 1 хүн зөвшөөрлийн цахим системд бүртгүүллээ.Одоо баримт бичиг боловсруулж үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн 2 иргэн байна.	90
4.2.13	УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрт дэд бүтцийн хамааралтай зорилтуудын	УТ, ОНТ	хэрэгжилтийн хувь	90	Эхний хагас жилд: - Жилийн	Аймгийн 2025 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгэм эдийн засгийн дэвшүүлсэн бодлого, зорилтыг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас баталсан "Төрийн хэмнэлтийн тухай"	100

	хэрэгжилтийг хангуулж, тайлагнах.				эцэст: 100	хуулийн хэрэгжилтийг Төсвийн бүх шатны байгууллага, төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлын эсрэг хязгаарлалт тогтоох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулан ажиллахыг төсвийн Ерөнхийлэн захирагчаас үүрэг чиглэл өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаа.	
4.2.14	Аймаг, сумын ИТХ-аар батлагдсан орон нутгийн төсвийн орлогыг цаг хугацаанд нь, татварын болон татварын бус орлогын нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлнэ.	ҮАЗ	Биелэлтийн хувь	100	Эхний хагас жилд: 80 Жилийн эцэст: 100	Орон нутгийн төсвийн орлогод эхний 10 сарын байдлаар 49,710.4 сая төгрөг орж, төлөвлөгөө 5,139.7.6 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар, үүнээс татварын орлогод 44,301.8 сая төгрөг орж төлөвлөгөө 5,748.2 сая төгрөгөөр буюу 11.5 хувиар тасарч, татварын бус орлогод 3,281.8 сая төгрөг орж төлөвлөгөө 526.7 сая төгрөгөөр буюу 119.1 хувиар, хөрөнгийн орлогод 2,126.8 сая төгрөг орж төлөвлөгөө 81.8 сая төгрөгөөр буюу 104 хувиар тус тус давж биелсэн үзүүлэлттэй байна. Улсын төсөвт 8,705.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 8,787.4 сая төгрөг төвлөрүүлж 100.9 хувийн биелэлттэй байна.	100
4.2.15	Батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээнд зориулан хэмнэлтийн горимыг баримтлан үр ашигтай зарцуулж, төсөв санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулна.	ҮАЗ	Үйл ажиллагааны хэвийн, жигд байдал, үр дүн /Хувиар/	88	Эхний хагас жилд: 89 Жилийн эцэст: 92	Төсвийн тухай хуулийн 37, 38 дугаар зүйл, Төрийн сангийн үйл ажиллагааны журам /2023 оны 12-р сарын 13-ний 444-р тогтоол/, Хэлтсийн даргын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу Сангийн Сайдын 2015 оны 90 дугаар тушаал, мөн Сангийн сайдын 2023 оны 121 дүгээр тушаалын дагуу төсвийн байгууллагуудын орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг батлагдсан төсвийн хуваарийн дагуу холбогдох хууль журмын дагуу Засгийн газрын удирдлага мэдээлийн системд бүртгэж төлбөрийг гүйцэтгэсэн. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг ханган биелүүлэх талаар зохиосон ажил, 1-3 дугаар улирлын төсвийн урьдчилсан гүйцэтгэлийн товч танилцуулгыг гаргаж удирдлагуудад танилцуулан цаашид авах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Орон нутгийн төсвийн нийт зарлага 102,241.2 сая төгрөгт хүрч, төсөвлөснөөс 20,484.5 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь 80 хувьтай байна. Үүнээс орон нутгийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зардал 35,067.2 сая төгрөг хүрч, 16,065.8 сая төгрөгөөр, боловсролын салбарын байгууллагуудын зардал 8,893.6 сая төгрөгт хүрч, 3,483.9 сая төгрөгөөр, соёл, спортын салбарын байгууллагуудын зарлага 986.5 сая төгрөгт хүрч, 479.9 сая төгрөгөөр, эрүүл мэндийн салбарын байгууллагын зарлага 836.9 сая төгрөгт хүрч, 403.9 сая төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэл гарсан урьдчилсан дүнтэй байна.	90
4.2.16	Аймаг, сумын төрийн сангаас батлагдсан төсвийн зарцуулалтанд	-	Үйл ажиллагааны хэвийн,	90	Эхний хагас жилд:	Сангийн сайдын 2024 оны 12 сарын 31-ний өдрийн 254 тоот тушаал Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврын дагуу 2025 онд төрийн сангийн нэгжүүдэд дотоод хяналт	90

	хяналт тавих, “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналт журам”-ын дагуу явуулах нөхцөл бололцоогоор хангаж, хэрэгжилтэнд хяналт тавина.		жигд байдал, үр дүн /Хувиар/		92 Жилийн эцэст: 94	хийх төлөвлөгөөг хугацаандаа хүргүүлж ажилласан. Дотоод хяналт хийх төлөвлөгөөний дагуу Ховд, Эрдэнэбүрэн суманд хяналт хийж ажиллалаа. Төрийн сангийн гүйлгээ хийхдээ гаргаж байгаа алдаа дутагдал, анхан шатны баримтын бүрдэл дутуу, эдийн засгийн ангилал, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээгээ гаргадаггүй, төрийн сангийн цахим архив үүсгээгүй, шилэн дансны мэдээллээ дутуу оруулсан, төсвийн санхүүжилт олгохдоо стандарт маягт хөтлөөгүй, хөрөнгө оруулалтын гүйлгээ хийхэд анхаарах ёстой асуудлууд анхан шатны баримт дутуу, сургууль цэцэрлэгийн нягтлан бодогч гүйлгээ хийхдээ цахим нэхэмжлэхээр гүйлгээ хийгээгүй зэрэг алдаа дутагдлуудыг арилгуулахаар зөвлөмж өгч зөвлөж ажиллалаа.	
4.2.17	Төсөв болон төсвийн гүйцэтгэлийн сар, улирлын мэдээ, тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын дагуу тайлагнана.	-	Мэдээний тоо Тайлан тоо	Мэдээ-12 Тайлан-4	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Мэдээ-12 Тайлан-4	Орон нутгийн 2025 оны төсвийн орлого, зарлага, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн сар, улирлын хуваарийг Сангийн сайдын 2024 оны 258 дугаар тушаалыг үндэслэн сум, байгууллага, орлогын төрөл, эдийн засгийн ангилалаар фискал програмд шивж баазыг Сангийн яаманд хүргүүлж, аймгийн Засаг даргын 1 дүгээр сарын 17-ны А/18 дүгээр захирамжийн 8 хавсралтаар батлан сум, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан зарлага, санхүүжилтийг хугацаанд нь олгож байна. 2025 оны сар, улирлын мэдээ, хагас жилийн тайланг цаглбаварын дагуу хугацаанд нь гарган цахимаар хүлээн авч Сангийн яаманд хянуулсан.	90
4.2.18	Орон нутгийн төсвийн төслийг боловсруулан Монгол улсын нэгдсэн төсвийн төсөлд тусгуулна.	-	Үйл ажиллагааны хэвийн, жигд байдал, үр дүн /Хувиар/	100	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Орон нутгийн төсвийн 2026 оны төсөл, 2027-2028 оны дунд хугацааны төсөөллийг боловсруулах удирдамж, заавар, хуваарийг боловсруулан сум, байгууллага, хэлтсүүдэд аймгийн Засаг даргын албан бичгүүдээр хүргүүлж, хуваарийн дагуу улс, орон нутгийн, бусад гадны эх үүсвэрийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын болон орон нутгийн төсвийн орлого, зардлын төслийг хүлээн авч нэгтгэж Сангийн яаманд хянууллаа. Аймгийн 2026 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн нийт орлогыг 47481,2 сая төгрөг байхаар тооцож, үүний 97,4 хувь буюу 45391,2 сая төгрөгийг татварын орлогоор, 2,7 хувь буюу 2040,0 сая төгрөгийг татварын бус орлогоор, 0,001 хувь буюу 50.0 сая төгрөгийг хөрөнгийн орлогоор бүрдүүлэхээр төлөвлөж, Сангийн яамаар 54204,6 сая төгрөгөөр хянууллаа.	100
4.2.19	Төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, цахим орчинд ажиллах	-	Арга хэмжээний тоо/	4	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 4	2025 оны 5-р сарын 6-нд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс болон Татварын мэргэшсэн зөвлөх нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан “Татварын хууль тогтоомж, эрх зүй, бүртгэл тайлагнал, практик хэрэглээ” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулж сургалтанд орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн	100

	чадварыг сайжруулна.					ажилтан, нягтлан бодогч 60 гаруй хүн оролцлоо. Мөн Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газраас зохион байгуулсан цахим сургалтанд аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын 30 гаруй нягтлан бодогч хамрагдлаа.1072 хувьцааны бүртгэл ногдол ашиг, хэрхэн арилжаалах баялгийн шударга хуваарилалтын талаар цэнхэр, ягаан тасалбар болон иргэдийн эзэмшиж буй хувьцааны бүртгэл,мэдээллийг шүүж өгөх,зах зээлд гарч байгаа шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах болон үнэт цаас гаргагчдад зөвлөгөө өгөх хөрөнгө оруулагчдыг бэлтгэх, макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал сэдвийн хүрээнд өдөрлөгт оролцогчдод дэлгэрэнгүй мэдээлэл хүргэж, үйлчилгээ үзүүллээ."Монголын хөрөнгийн бирж" ХК-аас санаачлан Санхүүгийн зохицуулах хороо, аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж байгаа энэхүү өдөрлөг нь иргэд олон нийтийн санхүүгийн мэдлэг тэр дундаа хөрөнгө оруулалт, хөрөнгийн зах зээлийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх ач холбогдолтой өдөрлөг боллоо. Санхүүгийн зохицуулах хорооноос 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, өнөөгийн нөхцөл байдал урьдчилан сэргийлэх арга хэмжээ, анхаарах асуудлууд цахим залилах гэмт хэргийн нөхцөл байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сэдэвт сургалтанд зохицуулалтын салбарын ажилтануудын хамт идэвхтэй хамрагдлаа.	
4.2.20	Татварын цахим технологи, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, төлбөр төлөх сувгийг өргөтгөх, орчин нөхцөлийг сайжруулна.	-	Татвар төлөх сувгийн тоо, мөнгөн дүн	Суваг-18	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Суваг-21	Татвар хураалтыг цахимжуулах, татвар хураалтын түвшинг нэмэгдүүлэхэд Аймгийн ЗДТГ-аас алслагдсан бүс нутаг, зах худалдааны төвүүдэд үйл ажиллагаа эрхлэгчдээс татвар хураахад туслалцаа үзүүлэн 3 киосик машин, Гэрэгэ пос төхөөрөмж-8, сумдын ЗДТГ-аас 7 Гэрэгэ пос төхөөрөмжийг байршуулан ажилласнаар татвар хураах ажиллагааг илүү хялбар, түргэн шуурхай ажиллах нөхцлөөр хангаж өгсөн. Мөн 2025 онд Төрийн цахим үйлчилгээ, зохицуулалтын газраас 22 киоск машиныг 16 сум болон аймгийн төвийн томоохон үйлчилгээний байгууллагуудад байршуулж иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.	100
4.2.21	Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээллэх, хяналт, хариуцлагыг сайжруулна.	-	Хэрэгжилтийн хувь	89	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 94	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс төсвийн захирагч, нягтлан бодогч нарт сар бүр чиглэл хүргүүлж, шилэн дансны мэдээллийг бүрэн, хугацаандаа оруулахыг анхааруулан хэрэгжилтийг хангуулж байна. Батлагдсан төлөвлөгөө, хуваарийг Шилэн дансны цахим хуудас, <a href="http://khovd.gov.mn/">http://khovd.gov.mn/</a> цахим сайт, мэдээллийн самбарт байршуулж, сар бүрийн 8-ны дотор	90

						мэдээллийг бүрэн мэдээллэж байна. Мөн орон нутгийн төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий гүйцэтгэлийг тухай бүр, сар, улирал тутам шилэн дансны цахим хуудсанд байршуулан ил тод мэдээллэж байна. Орон нутгийн 2025 оны төсвийн төлөвлөгөөг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэхээр аймгийн болон шилэн дансны веб сайтад хуулийн хугацаанд байршуулан 2025 оны 10 сарын 30-ны байдлаар Шилэн дансны хуулийн хэрэгжилт 157 байгууллага хуулийн хугацаанд 21,489 мэдээлэл, хугацаа хоцорсон 854 мэдээлэл, оруулаагүй 3,770 мэдээлэл байгаа бөгөөд хэрэгжилт 82 хувьтай байна.	
4.2.22	Банк бус санхүүгийн байгууллага, даатгал, хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны тайлан мэдээнд хяналт тавьж, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангана.	-	Үйл ажиллагааны хэвийн, жигд байдал, үр дүн /Хувиар/	94	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100	Банк бус санхүүгийн байгууллага, Даатгал, Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны тайлан мэдээнд хяналт тавьж, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна. 2025 он гарснаар Ховд аймагт шинээр 1 ББСБ-ын салбар нэмэгдсэн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар манай аймагт ББСБ-ын салбар 8, Хадгаламж зээлийн хоршоо 9, Даатгалын 7, салбар үйл ажиллагаагаа эрхлэн ажиллаж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг тогтмол зохион байгуулж орон нутгийн төлөөлөгч нарт гарын авлагыг постер болгон цувралаар хүргэж ажилладаг. Санхүүгийн залилан луйвар пирамид болон понзи схем сэдэвт гарын авлагыг хүлээн авч түгээн дэлгэрүүлж байна. Ирсэн мэдээлэл бүхий гарын авлагуудыг орон нутгийнхаа цахим хуудас, мэдээллийн самбар гэх мэтэд байршуулж ажиллалаа. 4- 6 сар хүртэлх хугацаанд Хорооноос гаргасан нийт 5 гарын авлагыг постер болгон олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор хүргүүлсэн. Постеруудыг харилцагч байгууллага, орон нутгийн мэдээллийн хуудас, өөрсдийн орон нутагт бүртгэлтэй зохицуулалтын байгууллагуудаараа дамжуулан түгээн ажиллаж байна	90
4.2.23	Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг сар бүр гаргаж тайлагнана	-	Санхүүжилтийн гүйцэтгэл /Хувиар/	76	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 86	Энэ оны 10 сарын байдлаар аймгийн 2025 оны төсөвт батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтын 61 төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн 12,324.1 сая төгрөгөөс 10,142.5 сая төгрөг нь шийдвэрлэгдэж 9,023.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 73.2 хувьтай, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын 66 төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн 22,440.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, арга хэмжээнээс 18,023.8 сая төгрөг нь шийдвэрлэгдэж 13,952.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 62.2 хувьтай, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр хэрэгжих 11 арга хэмжээний 1,088.3 сая төгрөгийн 698.3 сая төгрөг нь шийдвэрлэгдэж 6,677.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 62.2 хувьтай,	90

						<p>замын сангаар хэрэгжих 3 төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хөрөнгө оруулалтанд төлөвлөгдсөн 1,653.6 сая төгрөгийн 1,259.8 сая төгрөг нь шийдвэрлэгдэж 1,028.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 62.3 хувийн санхүүжилтийг тус тус олгосон байна.</p> <p>Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тухай бүр хяналт тавин ажилласан ба сар бүр цахим системээр үр дүнг тайлагнан ажилласан.</p>	
4.2.24	Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалыг бүх сумдад авна.	-	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ	14	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 17	Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалыг 14 сум 2,854.6 сая төгрөгийн урамшуулал авсан.	85
Нийт арга хэмжээ: 183						Гүйцэтгэлийн хувь - 92.2%	92.2

Үнэлсэн:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

.....

/М.АМАРСАНАА/

(албан тушаал)

(гарын үсэг)

2026.01.20

(огноо)

Тайлагнасан:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА.

.....

/Х.БААСАНХҮҮ/

(албан тушаал)

(гарын үсэг)

2026.01.20

(огноо)